



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ДЭЛХИЙН БАНКНЫ "МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ МОНСТАТ ТӨСӨЛ"

ДАЛД ЭДИЙН ЗАСГИЙГ ТООЦОХ СУДАЛГААНЫ НЭГДСЭН ТАЙЛАН, 2010 ОН



Улаанбаатар хот
2013 он



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

*ДЭЛХИЙН БАНКНЫ “МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН
ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ МОНСТАТ ТӨСӨЛ”*

ДАЛД ЭДИЙН ЗАСГИЙГ ТООЦОХ СУДАЛГААНЫ НЭГДСЭН ТАЙЛАН, 2010 ОН

Улаанбаатар хот
2013 он



DDC
310'517
X-822

Энэхүү тайлан нь англи хэл дээр хэвлэгдсэн болно.

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

**Монгол Улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу,
Засгийн газрын III байр
Утас: 326414, 322424
Вэб: www.nso.mn
И-мэйл: nso@magicnet.mn**

ISBN 978-99962-949-0-7

АГУУЛГА

Тайлан бичихэд оролцогчид.....	iv
Хүснэгтийн жагсаалт.....	vi
Зургийн жагсаалт.....	vii
Хавсралт хүснэгтийн жагсаалт.....	viii
Өмнөх үг.....	x
Товчилсон үгийн тайлбар.....	xi
БҮЛЭГ 1. ОЙЛГОЛТ, АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.....	13
1.1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....	15
1.2. ДАЛД ЭДИЙН ЗАСАГ (ДЭЗ)-ИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ.....	18
1.3. ДЭЗ-ИЙГ ТООЦОХ ҮНДСЭН ЗОРИЛГО.....	19
1.4. ХИЙГДСЭН СУДАЛГАА, ТООЦООЛОЛ, ТЭДГЭЭРИЙН ХАМРАХ ХҮРЭЭ.....	20
1.5. СУДАЛГАА, ТООЦООЛЛЫН ХАМАРСАН ХУГАЦАА.....	22
1.6. ЕРӨНХИЙ ЗАРЧИМ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.....	23
БҮЛЭГ 2. ДАЛД ЭДИЙН ЗАСГИЙГ ХЭМЖИХ СУДАЛГАА, ТООЦООЛОЛ.....	25
2.1. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА.....	27
2.1.1. ХӨДӨӨ АЖ АХУЙ, УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТООС БУСАД САЛБАРТ	
ЯВУУЛСАН “ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА”.....	27
Судалгааны түүвэрлэлт.....	27
Судалгааны асуулга, заавар.....	28
Судалгааны ахлагч, тоологч нарын сургалт.....	29
Мэдээлэл цуглуулалт.....	29
Мэдээлэл боловсруулалт.....	29
Мэдээллийг оруулах бүрдүүлэлтийн үе шат.....	29
Мэдээллийг засварлах үе шат.....	32
Мэдээллийн чанарын үнэлгээ.....	33
Орхигдсон утгыг тооцож орлуулсан арга зүй.....	33



Үр дүнгийн хүснэгтүүдийг бэлтгэсэн талаар.....	35
Судалгааны дүн.....	35
Хувиараа хөдөлмөр эрхлэгч нэгжийн тоо, тэдний бизнесийн үйл ажиллагааны төлөв байдал.....	35
Ажил эрхлэлт.....	40
Хувиараа хөдөлмөр эрхлэгч нэгжийн бүрдүүлж буй ний борлуулалт, үйлдвэрлэлт, завсрын хэрэглээ, нэмэгдэл өртөг.....	45
2.1.2 “БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН СУДАЛГАА”.....	53
Судалгааны асуулгын хуудас, түүний үзүүлэлтүүд.....	53
Судалгааны дүн.....	53
2.2. ХУУЛЬ БУС ҮЙЛДВЭРЛЭЛ.....	56
Мансууруулах бодисын худалдаа, хэрэглээ.....	56
Биеэ үнэлэх үйл ажиллагаа.....	57
2.3. НУУГДМАЛҮЙЛДВЭРЛЭЛ.....	57
БҮЛЭГ 3. ДАЛД ЭДИЙН ЗАСГИЙН НИЙТ ХЭМЖЭЭ.....	59
ДҮГНЭЛТ.....	64
ХАВСРАЛТ А – ХҮСНЭГТҮҮД.....	xiv
ХАВСРАЛТ Б – АСУУЛГЫН ХУУДАС.....	xv

Тайлан бичихэд оролцогчид

Удирдлагын зөвлөл:

С.Мэндсайхан	ҮСХ-ны дарга
Г.Гэрэлт-од	ҮСХ-ны тэргүүн дэд дарга
Б.Эрдэнэсүрэн	ҮСХ-ны дэд дарга

Тайлан бичиж боловсруулсан:

Б.Бадамцэцэг	МЭЗСГ-ын дарга
Б.Анхзаяа	МЭЗСГ-ын ахлах шинжээч

Техникийн зөвлөх:

Жири Воровил	Монстат төслийн зөвлөх
	Чех улсын Статистикийн газрын мэргэжилтэн



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1. ДЭЗ-ийн үйл ажиллагааны анги болон талбар.....	18
Хүснэгт 2.1. ХХЭН-ийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байршлаар.....	36
Хүснэгт 2.2. ХХЭН-ийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, бүсээр.....	36
Хүснэгт 2.3. ХХЭН-ийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, үндсэн үзүүлэлтүүдээр.....	38
Хүснэгт 2.4. ХХЭН-ийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, үндсэн ба хоёрдогч үйл ажиллагаагаар.....	39
Хүснэгт 2.5. ХХЭН-ийн тоо, ажлын байрны төрлөөр.....	40
Хүснэгт 2.6. ХХЭН-д ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар.....	42
Хүснэгт 2.7. ХХЭН-д ажиллагчдын тоо, бүсээр.....	43
Хүснэгт 2.8. ХХЭН-д ажиллагчдын 7 хоногт ажилласан хугацаа, суурьшлаар (%).....	44
Хүснэгт 2.9. ХХЭН-д ажиллагчдын 7 хоногт дундаж ажилласан цаг, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, суурьшлаар.....	44
Хүснэгт 2.10. ХХЭН-ийн тоо, жилийн борлуулалтын орлого, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар.....	46
Хүснэгт 2.11. ХХЭН-ийн тоо, жилийн борлуулалтын орлого, бүс, аймаг, нийслэлээр.....	47
Хүснэгт 2.12. Жилийн нийт үйлдвэрлэл, завсрын хэрэглээ, нэмэгдэл өртөг, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар.....	48
Хүснэгт 2.13. Жилийн нийт үйлдвэрлэл, завсрын хэрэглээ, нэмэгдэл өртөг, бүсээр.....	49
Хүснэгт 2.14. Жилийн нийт үйлдвэрлэл, завсрын хэрэглээ, нэмэгдэл өртөг, суурьшлаар.....	49
Хүснэгт 2.15. 1 ажилтны жилийн болон 1 цагийн дундаж үйлдвэрлэл.....	50
Хүснэгт 2.16. Бүтээмжийн үзүүлэлтүүд.....	51
Хүснэгт 2.17. Бичил уурхай эрхлэгчдийн тоо, бүсээр.....	53
Хүснэгт 2.18. Жилийн нийт үйлдвэрлэл, завсрын хэрэглээ, нэмэгдэл өртөг, бүсээр.....	54
Хүснэгт 2.19. Нэмэгдэл өртөг, бүрэлдэхүүн хэсгээр, бүсээр.....	56
Хүснэгт 2.20. Хууль бус үйлдвэрлэл (сая төгрөг), 2010 он.....	57
Хүснэгт 2.21. Орлогоо нуун дарагдуулсан хуулийн этгээдийн нуугдмал үйлдвэрлэл, 2010 он.....	58
Хүснэгт 3.1. Далд эдийн засгийн хэмжээ (сая төгрөг), 2010 он.....	61
Хүснэгт 3.2. Нийт эдийн засагт ДЭЗ-ийн эзлэх хувь (сая төгрөг), 2010 он.....	62



ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1. ХХЭС-ны хамрах хүрээ.....	21
Зураг 2.1. АХС-нд хамрагдсан өрхөөс ххэс-нд хамрагдах нэгжийг тодорхойлох схем.....	27
Зураг 2.2. Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газарт мэдээлэл боловсруулах схем.....	30
Зураг 2.3. ҮСХ-нд мэдээлэл боловсруулах схем.....	31
Зураг 2.4. ХХЭН-ийн тооны суурьшлийн бүтэц (%).....	33
Зураг 2.5. ХХЭН-ийн эзний ам бүлийн тоо.....	37
Зураг 2.6. ХХЭН-д ажиллагчдын тоо, ажил эрхлэлтийн байдлын бүтцээр.....	41
Зураг 2.7. ХХЭН-д ажиллагчдын тоо, сард ажилласан цагийн бүтцээр.....	42
Зураг 2.8. ХХЭН-д ажиллагчдын сарын дундаж цалин (төгрөг), бүсээр.....	43
Зураг 2.9. ХХЭН-д ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хот, хөдөө, хүйсээр (%).....	45
Зураг 2.10. Бүтээмжийн үзүүлэлтүүд, салбараар.....	52
Зураг 2.11. Бичил уурхай эрхлэгчдийн бүрдүүлж буй нэмэгдэл өртөг, ажил эрхлэлтийн байдлаар.....	54
Зураг 2.12. Нэг бичил уурхай эрхлэгчийн жилийн үйлдвэрлэлт, сая төгрөгөөр.....	55
Зураг 3.1. ДЭЗ-ийн хэмжээ, салбараар (%).....	63
Зураг 3.2. ДЭЗ-ийн нийт үйлдвэрлэлт, нэмэгдэл өртгийн харьцаа, салбараар (%).....	63



ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хувиараа хөдөлмөр эрхлэгч нэгжийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байршилаар, 2011 он.....	67
Хүснэгт 2. Хувиараа хөдөлмөр эрхлэгч нэгжийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, аймаг, бүсээр, 2011 он.....	68
Хүснэгт 3. Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажиллагчдын насны бүлгээр, 2011 он.....	69
Хүснэгт 4. Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил эрхлэлтийн байдлаар (%), 2011 он.....	70
Хүснэгт 5. Ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хүйсээр, 2011 он.....	71
Хүснэгт 6. Ажиллагчдын тоо, бүс, аймаг, хүйсээр, 2011 он.....	72
Хүснэгт 7. Ажиллагчдын ажилласан цаг, дундаж цалин, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, 2011 он.....	73
Хүснэгт 8. Ажиллагчдын сарын дундаж цалин, бүс, аймаг, хүйсээр, 2011 он.....	74
Хүснэгт 9. Хувиараа хөдөлмөр эрхлэгч нэгжийн нийт борлуулалт, үйлдвэрлэлт, завсрын хэрэглээ, нэмэгдэл өртөг, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, 2011 он	72
Хүснэгт 10. Хувиараа хөдөлмөр эрхлэгч нэгжийн нийт борлуулалт, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, 2011 он.....	76
Хүснэгт 11. Хувиараа хөдөлмөр эрхлэгч нэгжийн нийт борлуулалт, бүс, аймгаар, 2011 он.....	77
Хүснэгт 12. Хувиараа хөдөлмөр эрхлэгч нэгжийн нийт борлуулалт, бүс, аймгаар, 2011 он.....	78
Хүснэгт 13. Хувиараа хөдөлмөр эрхлэгч нэгжийн завсрын хэрэглээний бүрэлдэхүүн хэсгүүдийн эзлэх хувь, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, 2011 он	79
Хүснэгт 14. Хувиараа хөдөлмөр эрхлэгч нэгжийн нэмэгдэл өртгийн бүрэлдэхүүн хэсгүүдийн эзлэх хувь, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, 2011 он.....	80
Хүснэгт 15. Далд эдийн засгийн хэмжээ (сая төгрөг), эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, 2010 оны байдлаар.....	81

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж
АНДОЭЗНК	Ази, Номхон далайн орнуудын Эдийн засаг, нийгмийн комисс
АНУ	Америкийн нэгдсэн улс
АХС	Ажиллах хүчний судалгаа
БУС	Бичил уурхайн судалгаа
БРС	Бизнес регистрийн сан
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЭЗ	Далд эдийн засаг
ЗГ	Засгийн газар
НАХ	Нөөц ашиглалтын хүснэгт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НСГ	Нийслэлийн статистикийн газар
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НЦГ	Нийслэлийн цагдаагийн газар
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ОУВС	Олон улсын валютын сан
СХТ	Салбар хоорондын тэнцэл
ТАШН	Түүврийн анхан шатны нэгж
ТНДН	Түүврийн нутаг дэвсгэрийн нэгж
ТУХНОСХ	Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнуудын статистикийн хороо
ТХШН	Түүврийн хоёр дахь шатны нэгж
ТЕГ	Татварын ерөнхий газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮТС	Үндэсний тооцооны систем
ҮНО	Үндэсний нийт орлого
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ХХЭС	Хувиараа хөдөлмөр эрхлэлтийн судалгаа
ХХЭН	Хувиараа хөдөлмөр эрхлэгч нэгж
ШХА	Швейцарын хөгжлийн агентлаг
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

ӨМНӨХ ҮГ



Улс орны нийгэм, эдийн засгийн төлөв байдлын талаарх албан ёсны статистикийн үндсэн үзүүлэлтийг тооцох ажлын хүрээнд ҮСХ-ноос шинжлэх ухааны үндэслэлтэй арга зүйгээр цогц үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Улсын Их Хурлын 2011 оны 12 сарын 01-ний өдрийн 59 дүгээр тогтоолоор баталсан “Монгол улсын статистикийн салбарыг 2011-2015 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 6.2 хэсэгт “Дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоо, хамралт, мэдээллийн чанар, аргачлал, арга зүйг сайжруулах” зорилт тавьж, уг зорилтын хүрээнд “Далд эдийн засгийн хэмжээг тодорхойлно” гэж тусгагдсан билээ.

Дээрх зорилтын хүрээнд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага/ЭЗХАХБ/, Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн орнуудын статистикийн хороо /ТУХНОСХ/, Олон улсын хөдөлмөрийн байгууллага /ОУХБ/, Олон улсын валютын сан /ОУВС/, Нэгдсэн үндэстний байгууллагын Статистикийн хороо, Дэлхийн банкны хамтран боловсруулсан “Далд эдийн засгийн хэмжээг тооцох-2002” гарын авлага, Үндэсний тооцооны систем-2008 зөвлөмж болон НҮБ, ЕХ-ны улс орнуудын практикийг багтаасан “ДНБ-д ДЭЗ-ийг тооцож, тусгах нь” гарын авлагыг мөрдлөг болгож, далд эдийн засгийг бүхэлд нь тооцох судалгаа, тооцооллыг ҮСХ хийж, үр дүнг энэхүү тайланд нэгтгэлээ.

Уг тайлан нь “Судалгааны үндсэн үр дүн” болон хавсралт хэсгүүдээс бүрдэж байгаа болно. Тайлангийн эхний хэсэгт далд эдийн засгийн судалгааны арга зүй, зохион байгуулалт, ойлголт тодорхойлолт, хамрах хүрээ, үндсэн үзүүлэлтийн үр дүн, тооцоолол зэргийг авч үзсэн бол хавсралт хэсэгт судалгааны үр дүнгийн дэлгэрэнгүй хүснэгт, асуулгын хуудас зэргийг тусгав.

Монгол улсын далд эдийн засгийн өнөөгийн байдал, дүр төрхийг нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдтэй холбон судалсан энэхүү судалгааны үр дүн нь төрөөс далд эдийн засгийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг үнэлж дүгнэх, цаашид авч хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг боловсруулахад чухал хувь нэмэр болно гэж үзэж байна. Энэхүү судалгааг явуулснаар далд эдийн засгийн талаарх үндэсний хэмжээний мэдээллийн сантай болж, ҮСХ-ны боловсон хүчний чадавхийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулсныг энд тэмдэглэж байна. Судалгааны үр дүн нь далд эдийн засаг, үүн дотроо албан бус сектор болон албан бус ажил эрхлэлтийн талаарх бодит мэдээллээр хэрэглэгчдийг хангахын зэрэгцээ, энэ чиглэлээр ажилладаг судлаач, эрдэмтдэд сүүлийн үеийн шинэ мэдээлэл бүхий гарын авлага болно гэдэгт найдаж байна.

Судалгааны ажилд санхүү, техникийн дэмжлэг үзүүлсэн Дэлхийн банк, Швейцарын хөгжлийн агентлаг болон бидэнтэй хамтран ажиллаж, удаа дараагийн хэлэлцүүлэгт идэвхтэй оролцож, тооцооны мэдээллийн эх үүсвэрээр хангаж ажилласан Эрүүл мэндийн яам, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл судалгааны төв, Тагнуулийн ерөнхий газар, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Судалгааг удирдан зохион байгуулж, амжилттай явуулсан ҮСХ-ны МЭЗСГ-ын ажлын баг, зөвлөх ноён Жири Вонравилд талархлаа илэрхийлж байна.

ДАРГА

С.МЭНДСАЙХАН

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ОЙЛГОЛТ, АРГА ЗҮЙ, ЗОХИОН
БАЙГУУЛАЛТ

1.1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Үндэсний статистикийн хороо нь дэлхийн улс орны статистикийн байгууллагуудын нэгэн адил улс орны эдийн засаг дахь албан бус секторын үйл ажиллагааны үр дүнг дотоодын нийт бүтээгдэхүүнд тусгах талаар тодорхой ажлыг үе шаттай авч хэрэгжүүлсээр ирсэн.

Бүртгэгдээгүй буюу далд эдийн засгийн хэмжээг тодорхойлох ажлыг 1997 оноос эхлэн олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр явуулж эхэлсэн бөгөөд анх удаа Дэлхийн Банкны зөвлөх Билл Бикалис (Bill Bikales)-ийн удирдлага дор 1999 онд явуулсан судалгааны үр дүнд үндэслэн албан бус секторын дийлэнх хувийг бүрдүүлж байсан жижиглэн худалдаа (ТҮЦ, хотын гудамж, талбайд болон бараа, техникийн захуудад арилжаа хийж байгаа жижиг худалдаа эрхлэгч), тээвэр (таксины жолооч), зоогийн газрын салбарын гүйцэтгэлийг 2000 оны албан ёсны дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоонд анх удаа тусгаж, түүнээс хойших онуудын тооцоог тухайн оны хэрэглээний үнийн өөрчлөлт, лиценз, патенттай иргэдийн тоог үндэслэн тооцож ирсэн.

Аж ахуйн нэгж, байгууллагын 2006 оны тооллогод орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй үйл ажиллагаа эрхлэгчдийг хамруулж, тэдгээрийн үйл ажиллагааны талаарх мэдээллийн санг бүрдүүлсэн. Судалгааны үр дүнд үндэслэн хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн үйл ажиллагааг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилан 2006 оны дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоонд хамруулж, өмнөх онуудын динамикийг шинэчлэх ажлыг гүйцэтгэсэн.

Албан бус сектор болон албан бус хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр 5 төрлийн судалгаа хийгдсэн. Үүнд:

1. АНУ-ын Олон улсын хөгжлийн байгууллага (USAID)-аас 2000 онд явуулсан “Албан бус секторын судалгаа / Билл Бикалис/”
2. Азийн хөгжлийн банкны санхүүжилтаар ҮСГ /хуучин нэрээр/-аас явуулсан 2002-2003 оны “Ажиллах хүчний судалгаа”
3. Шинжлэх ухаан технологийн сангийн санхүүжилтээр ҮСГ /хуучин нэрээр/-аас явуулсан “Тээвэр, худалдааны салбарын албан бус секторын судалгаа”
4. Нээлттэй нийгэм форум-Соросын сангийн санхүүжилтээр ҮСГ /хуучин нэрээр/-аас явуулсан “Далд эдийн засгийн судалгаа”
5. НҮБ-ын АНДОЭЗНК-ын санхүүжилтээр ҮСХ-ноос “Ажиллах хүчний судалгаа”-ны нэмэлт модуль болгон явуулсан “Хувиараа хөдөлмөр эрхлэлтийн 2007-2008 оны судалгаа”

АНУ-ын Олон улсын хөгжлийн байгууллагаас 2000 онд явуулсан албан бус секторын судалгаа. Энэхүү судалгааг ТҮЦ, лангуу, чингэлэгийн худалдаа, такси, микро автобус, цайны газар, авто машин болон гэр ахуйн барааны засвар зэрэг 15 төрлийн үйл ажиллагааг хамруулан Улаанбаатар хот болон Дархан-Уул, Орхон зэрэг цөөн тооны аймагт явуулсан. Судалгааг зөвхөн тухайн үйл ажиллагааг явуулагч нэгжид чиглэн явуулсан. Судалгааны дүнг 2000-2005 оны албан бус секторын нэмэгдэл өртгийн тооцоонд ашиглаж ирсэн.

Сангийн яамны захиалгаар Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилтээр ҮСГ (хуучин нэрээр)-аас явуулсан Тээвэр, худалдааны салбарын албан бус секторын 2004 оны судалгаа. Тээвэр, худалдааны салбарын ТҮЦ, лангуу, чингэлэгийн худалдаа, гутал засвар, автомашин, гэр ахуйн барааны засвар авто зогсоол, хот хоорондын ачаа болон зорчигч тээвэрлэлт, хотын доторх нийтийн тээвэр, такси, хотын доторх ачаа тээвэрлэлт зэрэг 12 төрлийн үйл ажиллагааг хамруулан Улаанбаатар хот, Дорноговь, Дорнод, Завхан, Хөвсгөл, Дархан-Уул, Орхон аймгуудад 2004 онд судалгааг явуулсан. Худалдааны салбарын нэмэгдэл өртгийн тооцоонд судалгааны үр дүнг ашиглаж ирсэн.

Нээлттэй нийгэм форум-Соросын сангийн санхүүжилтээр ҮСГ (хуучин нэрээр)-аас явуулсан Далд эдийн засгийн судалгаа. Судалгааг АНУ-ын Мэрилэйндийн их сургууль, АЙРИС төвийн туслалцаатайгаар 2004 оны 10-р сарын 15-наас 11-р сарын 8-ны хооронд 5 бүсийг төлөөлсөн 9 аймаг (Архангай, Дорноговь, Завхан, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Увс, Хөвсгөл, Орхон)-ийн 25 сум болон Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн нийт 19000 өрхөд явуулсан.

“Ажиллах хүчний судалгаа”-ны нэмэлт модуль болгон явуулсан “Хувиараа хөдөлмөр эрхлэлтийн 2007-2008 оны судалгаа”. Судалгааг НҮБ-ын АНДОЭЗНК (UNESCAP) болон Урт хугацааны анализ, хөгжлийн институт (DIAL)-ээс санал болгож 1990-ээд оноос хойш Мексик, Перу, Баруун Африк, Мадагаскар, Хятад, Бангладеш зэрэг улсуудад явуулсан “1-2-” аргыг ашиглан явуулсан. Хувиараа хөдөлмөр эрхлэлтийн судалгаа нь бүтэн нэг жилийг хамарч, улирлын нөлөөллийг бүрэн тусгаснаараа онцлог юм. Энэ судалгааны үндсэн зорилго нь албан бус хөдөлмөр эрхлэлтийн хэмжээ, албан бус секторт ажиллагчдын бий болгож буй нэмэгдэл өртгийн хэмжээг тодорхойлох явдал байсан. Харин хувиараа хөдөлмөр эрхлэлтийн судалгааны хувьд дээрх ажиллах хүчний судалгаанд хамрагдсан 7008 өрхөөс албан бус секторын хүрээг тодорхойлох нэмэлт шалгуурыг тавьж, 1558 нэгж хамрагдсан байна. Манай орны хувьд ҮСХ-нд тогтмол явагдаж байгаа судалгааны асуулгыг өргөжүүлэн нэмэлт асуултыг тусгаж, хувиараа хөдөлмөр эрхлэлтийн судалгаанд хамрагдах нэгжийг шууд тодорхойлсноороо ач холбогдолтой байлаа.

Хэдийгээр албан бус секторын нэмэгдэл өртгийн тооцоог дээрх судалгаануудын үр дүнг ашиглан хийж, ДНБ-д тусгаж байгаа ч тооцоог шинэчлэн, сайжруулах, түүнчлэн далд эдийн засгийн ойлголт, хамрах хүрээнд багтдаг бусад үйл ажиллагааг тооцоонд хамруулах, тооцооллыг бүрэн хийх шаардлага тавигдсаар байна.

Улсын Их Хурлын 2011 оны 12 сарын 01-ний өдрийн 59 дүгээр тогтоолоор баталсан “Монгол улсын статистикийн салбарыг 2011-2015 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 6.2 хэсэгт “Дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоо, хамралт, мэдээллийн чанар, аргачлал, арга зүйг сайжруулах” зорилт тавьж, уг зорилтын хүрээнд “Далд эдийн засаг (ДЭЗ)-ийг тодорхойлох” талаар мөн тусгагдсан билээ.

ҮСХ нь ЭЗХАХБ, ТУХНОСХ, ОУХБ, ОУВС, НҮБ-ын Статистикийн хороо, Дэлхийн банкны хамтран боловсруулсан “Далд эдийн засгийн хэмжээг тооцох-2002” гарын авлага, Үндэсний тооцооны систем-2008 зөвлөмж болон НҮБ, ЕХ-ны улс орнуудын практикийг багтаасан “ДНБ-д ДЭЗ-ийг тооцож, тусгах нь” гарын авлага зэргийг мөрдлөг болгож, Далд эдийн засгийн хэмжээг N1-N7 талбараар анх удаагаа тооцлоо.

Энэхүү тооцооллыг хийхэд Монгол улсын статистикийн салбарын чадавхийг бэхжүүлэх чиглэлээр ҮСХ-нд хэрэгжиж байгаа Монстат төслийн санхүүжилтээр Чех улсын зөвлөх Жири Вонравил мөн хамтран ажилласныг тэмдэглэж байна.

Албан бус сектор, албан бус ажил эрхлэлтийг тодорхойлохдоо ДЭЗ-ийн N1, N5 талбараар тодорхойлж, өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэл болох N3 талбарыг тусгайлан тодорхойлсон нь ҮТС-2008 зөвлөмж болон ОУХБ-аас гаргасан гарын авлагад бүрэн нийцсэнээс гадна өмнөх судалгааны аргазүйд үндэслэн энэ удаагийн судалгааг явуулснаар улс орнуудын түвшинд харьцуулагдахуйц мэдээлэлтэй боллоо гэж дүгнэж байна.

ДЭЗ-ийг тооцох ажлын хүрээнд ҮСХ-ны зүгээс хэд хэдэн судалгаа, тооцооллыг хийсэн. “Хувиараа хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”-г 2012 онд улсын хэмжээнд зохион байгуулан явуулж, судалгааны үр дүнгээр албан бус секторын үйлдвэрлэлийг тодорхойлсон. Түүнчлэн холбогдох захиргааны мэдээллийн эх үүсвэрээр ДЭЗ-ийн бусад талбар болох хууль бус үйлдвэрлэл, нуугдмал үйлдвэрлэлийг жилээр тооцлоо.

Хувиараа хөдөлмөр эрхлэлтийн судалгааг цаашид 5 жилийн давтамжтайгаар явуулж, судалгаа явуулаагүй завсрын онуудад албан бус секторын нэмэгдэл өртгийн тооцоог өмнөх судалгааны дүн болон Ажиллах хүчний судалгаагаар тодорхойлогдсон нэгжийн мэдээлэл зэрэгт үндэслэн тооцох, харин ДЭЗ-ийн бусад талбарын тооцоог жил бүр тооцох боломжтой гэж үзэж байна.

1.2. ДАЛД ЭДИЙН ЗАСАГ (ДЭЗ)-ИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Үндэсний тооцоонд хамрагдаагүй нуугдмал, хууль бус, албан бус үйл ажиллагаа, өөртөө зориулсан өрхийн хэрэглээний үйлдвэрлэл болон мэдээллийг бүрэн цуглуулж чадахгүй байгаагаас шалтгаалан албан ёсны мэдээллээс орхигддог үйл ажиллагааг нийтэд нь **далд үйл ажиллагаа** гэж нэрлэдэг бөгөөд тэдгээрийг үндэсний тооцоонд хамруулахыг **далд эдийн засаг (ДЭЗ)-ийг тооцох** гэж ойлгож тодорхойлдог.

ДЭЗ-ийг тооцох олон аргууд байдаг бөгөөд тэдгээрээс өөрийн орны онцлогт тохируулан тодорхойлох нь чухал юм.

ДЭЗ-ийн дотоод мөн чанар, статистик ажиглалтаас орхигддог үйл ажиллагааг тооцох гол арга зам бол тодорхой дүн шинжилгээний арга зүйн системийг ашиглах явдал юм. Дүн шинжилгээний системд статистик ажиглалтаас орхигдсон байж болох үйл ажиллагааг бүлэглэж, тэдгээрийг тодорхойлох, тооцооны аргуудын хэрэглээ багтана. Дээрх бүлгүүдийг тодорхойлохдоо статистик ажиглалтаас гадуур үлддэг үйлдвэрлэлийг бүрэн хамруулах зорилгоор тэдгээрийг өөр хооронд нь зааглаж, нэгтгэн тооцож болох хүрээнд бүлэглэсэн байх ёстой. Энэ хүрээнд, ДЭЗ-ийн үйл ажиллагааг дараах 5 ангилалд ангилдаг.

1. Нуугдмал үйлдвэрлэл (татвар, НДШ төлөх, стандартыг мөрдөхөөс зайлсхийх)
2. Хууль бус үйлдвэрлэл (хар тамхи, биеэ үнэлэх г.м үйл ажиллагаа)
3. Албан бус секторын үйлдвэрлэл
4. Өрхийн өөрийн хэрэглээний үйлдвэрлэл
5. Мэдээллийн бүрэн бус байдал (ААН-ийг мэдээлэлд хамруулаагүй, ААН-аас мэдээлэл өгөөгүй, буруу мэдээлсэн, болон боловсруулалтын алдаа)

Дээрх ангилал нь ДЭЗ-ийн дотоод мөн чанарыг ерөнхийд нь харуулж буй бөгөөд статистик ажиглалтаас гадна үлдсэн үйл ажиллагааны онцлогийг тусгасан дараах 7 талбар (**N1-N7**) -ыг авч үздэг.

ХҮСНЭГТ 1.1. ДЭЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АНГИ БОЛОН ТАЛБАР

ДЭЗ-ийн асуудал бүхий анги	Түүний талбар
1. Нуугдмал үйлдвэрлэл	N6 - Мэдээллийг “буруу” өгсөн хуулийн этгээд
2. Хууль бус үйлдвэрлэл (хар тамхи, биеэ үнэлэх гэх мэт)	N2 - Хууль бус үйлдвэрлэгчид
3. Албан бус секторын үйлдвэрлэл	N1 - Бүртгэгдээгүй үйлдвэрлэгчид - далд/нууц N5 - Судалгаанд хамрагдаагүй, бүртгэлтэй бизнес эрхлэгч
4. Өрхийн өөрийн хэрэглээний үйлдвэрлэл	N3 - Бүртгүүлэх шаардлагагүй үйлдвэрлэгчид
5. Мэдээллийн бүрэн бус байдал	N4 - Судалгаанд хамрагдаагүй, бүртгэлтэй хуулийн этгээд N7 - Бусад

N1. Бүртгэгдээгүй үйлдвэрлэгчид: Татвар, НДШ төлөхөөс зайлсхийж, бүртгүүлээгүй үйлдвэрлэгчид. Ихэнхдээ татвар төлөх босго түвшингээс өндөр борлуулалт хийдэг, жижиг нэгжүүд байна (гар урлал, барилгын засвар үйлчилгээ эрхэлдэг жижиг нэгжүүд).

N2. Хууль бус үйлдвэрлэгчид: Биеэ үнэлэх, хулгайлсан зүйлс борлуулах, мансууруулах бодис худалдах, үйлдвэрлэх, тээвэрлэх, барааг хууль бусаар хил давуулах, зөвшөөрөлгүй хуулбарлан борлуулах, мөрийтэй тоглоом зэрэг үйл ажиллагаа хамаарна.

N3. Бүртгүүлэх шаардлагагүй үйлдвэрлэгчид: Өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэл явуулж байгаа болон хувьдаа орон сууц барих, засварлах үйл ажиллагаа орно.

N4. Судалгаанд хамрагдаагүй, бүртгэлтэй хуулийн этгээд: Хуулийн этгээд нь бүртгэгдсэн хэрнээ БРС болон ААН-ийн судалгаанд хамрагдаагүй, орхигдсон, түүнчлэн БРС-д бүртгэгдээгүй, үзүүлэлтүүд нь шинэчлэгдээгүй буюу буруу байгаа хуулийн этгээд энэ талбарт хамарна.

N5. Судалгаанд хамрагдаагүй бизнес эрхлэгч: БРС-д хамрагдаагүй бизнес эрхлэгчид /БРС-д зарим төрлийн бизнес эрхлэгчдийг бүртгээгүй байдаг/, чөлөөт уран бүтээлч: жүжигчид, тамирчид, сэтгүүлч, зөвлөх, багш, зохиолч зэрэг бизнес эрхлэгчид энэ талбарт хамаарна.

N6. Мэдээллийг “буруу” өгсөн үйлдвэрлэгчид: Орлогын татвар болон НӨАТ, НДШ төлөхөөс зайлсхийхийн тулд орлогоо дутуу мэдээлэх эсвэл зардлаа илүү тайлагнадаг үйлдвэрлэгчдийг энд хамруулна.

N7. Бусад:

- N7a: мэдээлэл нь бүрэн бус, мэдээлэгч шууд нөхөх боломжгүй /биетээр олгосон цалин, хөлс, зах зээлийн үйлдвэрлэгчийн өөрийн эцсийн хэрэглээнд зориулсан үйлдвэрлэл, гарын мөнгө/ үзүүлэлтүүдийг энд хамруулна.
- N7b: боловсруулалтын үеийн алдаа /үнэлгээний арга техник, засварлалтыг сайжруулах/ энд хамаарна.

1.3. ДЭЭ-ИЙГ ТООЦОХ ҮНДСЭН ЗОРИЛГО

ДЭЭ-ийн хэмжээг тооцох нь дараах 3 үндсэн зорилготой. Үүнд:

- Үндэсний тооцооны хамралтыг нэмэгдүүлж, эдийн засгийн цар хүрээг бүрэн хэмжээгээр тодорхойлох
- Бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдыг шаардлагатай бодит тоон мэдээллээр хангах
- ДЭЭ-ийн талаарх олон улсын түвшинд зэрэгцүүлэгдэхүйц мэдээллийг бий болгох

1.4. ХИЙГДСЭН СУДАЛГАА, ТООЦООЛОЛ, ТЭДГЭЭРИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

ДЭЗ-ийн хамрах хүрээнд багтах талбаруудыг тооцож, тодорхойлох зорилгоор дараах судалгааг явуулж, холбогдох тооцооллыг хийсэн.

1.4.1. Хувиараа хөдөлмөр эрхлэлтийн судалгаа

- ХАА, уул уурхай, олборлолтоос бусад салбарт явуулсан “Хувиараа хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”
- “Бичил уурхай эрхлэгчдийн судалгаа”

1.4.2. Бизнесийн орлогоо нуун дарагдуулсан ААН, хуулийн этгээдийн үнэлгээ, тооцоолол

1.4.3. Хууль бус үйлдвэрлэлийн тооцоолол

1.4.1. Хувиараа хөдөлмөр эрхлэлтийн судалгаа

ХХЭС-ны хүрээнд ХАА, уул уурхай, олборлолтоос бусад салбарт үйл ажиллагаа явуулж буй өрхөд суурилсан түүвэр судалгаа, уул уурхай, олборлолтын салбарт үйл ажиллагаа явуулдаг бичил уурхай эрхлэгч, тэдгээрт туслах үйл ажиллагаа эрхлэгчдийг хамарсан тусгайлсан судалгааг явуулсан.

Манай орны эдийн засгийн салбарын онцлогийг харгалзан үзэж, өрхөд суурилсан албан бус секторын судалгаанд уул уурхайн салбар болон ХАА-н салбарыг хамруулаагүй болно.

Өмнө нь явуулсан ХХЭС-ны үр дүнгээс дүгнэлт хийж, бичил уурхай эрхлэгч иргэдийн хувьд тусгайлсан судалгааг ШХА-ийн санхүүжилтээр явуулсан. ХАА-н салбарын хувьд Монгол улсын “Статистикийн тухай хууль”-нд заасны дагуу жил бүр “Мал, тэжээвэр амьтдын тооллого”-ыг явуулж, түүнд үндэслэн салбарын үйлдвэрлэлийн хэмжээг тооцдог байдлыг харгалзан үзсэн болно.

Албан бус секторын үйлдвэрлэлийн хамрах хүрээнд ҮТС-2008 зөвлөмжийн секторын ангилалд «unincorporated household enterprises» (хувиараа хөдөлмөр эрхлэгч өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж) гэж тодорхойлогдсон дэд секторыг хамруулж авч үзсэн.

- Хувиараа хөдөлмөр эрхлэгч нэгж (ХХЭН). Хөдөө аж ахуйн бус, аж ахуйн зохион байгуулалтад ороогүй албан ёсны бүртгэл, нийгмийн хамгаалалд бүрэн хамрагдаагүй, зах зээл дээр бүтээгдэхүүн, үйлчилгээгээ борлуулдаг бизнесийн нэгжүүдийг ХХЭН гэж тодорхойлно. Энэ нь ихэвчлэн жижиг бизнесүүд байх бөгөөд заримдаа дангаараа бизнес эрхэлдэг байж болно.

Хувиараа хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэлт, хуваарилалт нь хууль ёсных байдгаараа онцлогтой.

- “Аж ахуйн зохион байгуулалтад ороогүй” гэдэг нь холбогдох хуулийн дагуу хоршоо, нөхөрлөл, компанийн хэлбэрээр аж ахуй эрхэлдэггүй, өрхийн нэг гишүүн эсвэл түүнээс дээш тооны өрхийн гишүүний эзэмшилд байдаг үйлдвэрлэл, үйлчилгээний хэлбэрийг хэлнэ.

ХХЭН нь дараах 2 шинж чанартай байна.

- ХХЭН нь тодорхой хүмүүсийн хөдөлмөр эрхлэлт, орлогыг бүрдүүлэхэд чиглэсэн бараа, үйлчилгээ үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжээс бүрдэнэ.

- ХХЭН өрхийн үйлдвэрлэлийн шинж чанарыг үндсэнд нь агуулна.

ХХЭС нь үр дүнгээс ДЭЗ-ийн албан бус сектор болон өрхийн өөрийн хэрэглээний үйлдвэрлэлийн ангийг тооцлоо.

1.4.1.1. Албан бус секторын үйлдвэрлэл: Албан бус сектор нь өрхийн дэд сектор юм.


Албан бус секторт албан ёсны бүртгэл, мэдээлэл, татварт бүрэн хамрагддаггүй, орлогыг нь тодорхойлоход бэрхшээлтэй хэдий ч орлого олох зорилгоор бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хамруулна. Албан бус секторт хамрагдах ХХЭН нь бүртгэлтэй болон бүртгэлгүй гэж 2 ангилагдана.

1.4.1.2. Өрхийн өөрийн хэрэглээний үйлдвэрлэл: ХСОУ-ын 15-р Бага Хурлын Тогтоолд “хэрэв үйлдвэрлэл нь өрхийн аж ахуйн зохион байгуулалтад ороогүй үйлдвэрийн нэгжид үйлдвэрлэгдэж, өрхийн эздийн өөрсдийнх нь эцсийн хэрэглээнд зарцуулагдаж байгаа бол түүнийг албан бус секторын хэсгээс салангид авч үзнэ” гэж заасны дагуу энэ үйлдвэрлэлийг ДЭЗ-ийн асуудал бүхий тусгай талбар болгон тооцоонд орууллаа.

Өрхийн өөрийн хэрэглээний үйлдвэрлэлийн хамрах хүрээнд дараах үйл ажиллагаа орно. Үүнд:

- Өөрийн эзэшлийн орон сууцны байшин барих, үндсэн хөрөнгийн хуримтлал бий болгох үйл ажиллагаа
- Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа

ЗУРАГ 1.1. ХХЭС-НЫ ХАМРАХ ХҮРЭЭ



1.4.2. **Нуугдмал үйлдвэрлэлийн тооцоолол:** 2010 онд үйл ажиллагаа явуулсан 35276 аж ахуйн нэгжийг хамруулж тооцоо хийсэн.

1.4.3. **Хууль бус үйлдвэрлэлийн тооцоолол:** Мансууруулах бодисын худалдаа болон биеэ үнэлэх үйл ажиллагааг хамруулж, 5.0 мянга гаруй иргэдэд үндэслэн тооцоо хийсэн.

1.5. СУДАЛГАА, ТООЦООЛЫН ХАМАРСАН ХУГАЦАА

ДЭЗ-ийг хэмжих хүрээнд хийгдсэн тооцоололд хугацааны хувьд зөрүүтэй, мэдээллийн олон эх үүсвэр ашиглагдсан бөгөөд тэдгээрийг ижил суурьтай болгох нэмэлт тооцоолол хийгдсэн болно. Судалгаа, тооцооллыг дараах хугацааг хамруулж хийсэн.

1.5.1. Хувиараа хөдөлмөр эрхлэгчийн судалгааг 2012 оны III, IV улиралд явуулж, 2011 оны үйл ажиллагааг хамруулан судалсан.

1.5.2. Бизнесийн орлогоо нуун дарагдуулсан хуулийн этгээдийн үнэлгээ, тооцооллын мэдээллийг 2010 оны эх үүсвэрт суурилан хийсэн.

1.5.3. Хууль бус үйлдвэрлэлийн тооцооллын мэдээллийг 2010 оны эх үүсвэрт үндэслэн хийсэн.

Монгол Улсын “Статистикийн тухай” хуулинд заасны дагуу 2010 оны гүйцэтгэлд суурилан зохиосон НАХ, СХТ-ийн үр дүнд ашиглах зорилгоор ДЭЗ-ийн хэмжээг 2010 оны байдлаар шилжүүлэн, холбогдох тооцооллыг хийсэн.

1.6. ЕРӨНХИЙ ЗАРЧИМ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Дээр тэмдэглэсэнчлэн, ДЭЗ-ийн хэмжээг тооцох ажлын хүрээнд ерөнхий зарчим, зохион байгуулалтын хувьд ялгаатай хэд хэдэн судалгаа, тооцоолол хийгдсэн.

ХАА, уул уурхай, олборлолтоос бусад салбарт явуулсан ХХЭС-г НҮБ-ын АНДОЭЗНК болон Францын Хөгжил, Урт хугацааны судалгааны институтээс зөвлөмж болгосон 1990-ээд оноос хойш Мексик, Перу, Баруун Африк, Мадагаскар, Хятад, Бангладеш зэрэг улсуудад хэрэгжүүлсэн “1-2-” аргыг ашиглаж явуулсан. Энэхүү арга нь Ажиллах хүчний судалгаа болон Албан бус секторын судалгааг дараалуулан 2 үе шаттайгаар явуулдаг арга юм.

Бичил уурхай эрхлэгчдийн судалгааг хамралт сайтай явуулах, судалгааны ажлыг дүгнэх, хяналт, үнэлгээ хийх, холбогдох арга хэмжээ авах, нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн дэмжлэг үзүүлэх, судалгааны үр дүнг тайлагнах ажлын хэсгийг байгуулж ажилласан. Ажлын хэсэгт Үндэсний статистикийн хороо, Швейцарийн хөгжлийн агентлагийн “Тогтвортой бичил уурхай” төсөл, холбогдох яам, газрын төлөөллийг оролцуулсан. Судалгааг орон нутагт удирдан зохион байгуулах, судалгааны явц болон тулгарч буй асуудлын талаар ажлын хэсгийн гишүүдэд танилцуулж байх, холбогдох арга хэмжээ авч ажиллах үүрэг бүхий аймаг, нийслэл, сум, дүүргийн ажлын хэсгийг байгуулан ажилласан. Бичил уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа цэгийг газарзүйн мэдээллийн системтэй холбосон.

Судалгааны ахлагч (аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газар) нар нь аймаг, нийслэлийн мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулж явуулсан. Аймаг, нийслэлийн судалгааны үйл ажиллагааны санхүү, зохион байгуулалтын асуудлыг ахлагч нар хариуцан ажилласан. Түүнчлэн аймаг, нийслэлийн мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулж мэдээллийн үнэн бодит байдлыг хариуцаж ажилласан. Судалгааны мэдээлэл цуглуулах ажилтнуудыг тухайн аймаг, дүүргийн өрхийн тоо, орд газрын байршлаас хамааруулан ярилцлага авагч нарын бүлгийг байгуулан удирдаж ажилласан.

Мэдээлэл цуглуулагчдад заавар, зөвлөгөө өгөх, мэдээллийн үнэн бодит байдлыг хангуулах, нөхөгдсөн асуулгыг шалгаж кодлох, тооцоог хийх зэрэг үүргийг ахлагч нар хүлээсэн ДЭЗ-ийн хүрээнд нуугдмал үйлдвэрлэл, хууль бус үйлдвэрлэлийг холбогдох захиргааны мэдээлэлд үндэслэн, албан бус сектор, өрхийн өөрийн хэрэглээний үйлдвэрлэлийг тооцохдоо “Хувиараа хөдөлмөр эрхлэлтийн судалгаа-2011”-ны дүнд үндэслэн шууд аргаар тооцооллыг хийсэн.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ДАЛД ЭДИЙН ЗАСГИЙГ ХЭМЖИХ
СУДАЛГАА, ТООЦООЛОЛ

2.1. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА

2.1.1. ХӨДӨӨ АЖ АХУЙ, УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТООС БУСАД САЛБАРТ ЯВУУЛСАН “ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГАА”

Судалгааны түүвэрлэлт

АХС-ны түүвэрлэлтээс дэд түүвэрлэлт хийх замаар түүврийн дизайныг тодорхойлсон. ХХЭС-нд АХС-наас дараах шалгуураар тодорхойлсон ХХЭН-ийг хамруулсан.

Шалгуур:

ЗУРАГ 2.1. АХС-НД ХАМРАГДСАН ӨРХӨӨС ХХЭС-НД ХАМРАГДАХ НЭГЖИЙГ ТОДОРХОЙЛОХ СХЕМ



Дээрх шалгуураар улсын хэмжээний ХХЭН сонгогдож, АХС-ны жинг шууд ашигласан.

Түүврийн арга техник, хэмжээ

АХС нь Монгол улсын Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын хүн ам, өрхийн мэдээнд үндэслэн түүврийн хүрээг тогтоосон.

АХС-ны түүвэрлэлтийн хэмжээ нь судалгааны төсөвт нийцүүлэн үнэлэгдэж, үндэсний хэмжээнд 4 хувиас хэтрэхгүй алдааны магадлалтай ба түүвэрлэлтийн загварын нөлөөний утга нь 1.5-аас хэтрэхгүй байхаар түүвэрлэлтийг хийсэн. Нийт түүврийн хэмжээ 12820 байснаас дэд түүвэрлэлт хийж, 3008 ХХЭН судалгаанд хамрагдахаар сонгогдсон.

Түүврийн анхан шатны нэгж (ТАШН)-ээр Монгол Улсын ХАОСТ-2010-ын ТНДН нэгжийг авсан. Түүврийн хоёр дахь шатны нэгж (ТХШН) нь өрх байлаа.

Судалгааны асуулга, заавар

Судалгааны зорилго, зорилтууд, хамрах хүрээг харгалзан судалгааны асуулга, ярилцлага авагч нарт зориулсан зааврыг Францын Хөгжил, урт хугацааны судалгааны институтийн боловсруулсан “1-2” судалгаанд ашигласан асуулга дээр үндэслэн Монгол орны нөхцөл байдалтай уялдуулан зохиосон.

Уг асуулга нь хувиараа хөдөлмөр эрхлэгч нэгжүүдийн талаарх мэдээллийг багтаасан 7 үндсэн бүлгээс бүрдэж байна. Үүнд:

Бүлэг 1. Хаягийн хэсэг: Судалгаанд хамрагдаж байгаа нэгжийн байршил, үйл ажиллагааны чиглэлийн мэдээллийг цуглуулсан.

Бүлэг 2. Ерөнхий мэдээлэл: Судалгаанд хамрагдаж байгаа нэгжийн талаарх ерөнхий мэдээлэл багтаж, үйл ажиллагаа эрхлэгчийн болон нэгжийн ерөнхий мэдээллийг цуглуулсан.

Бүлэг 3. Бизнесийн үйл ажиллагааны төлөв байдал, зохион байгуулалт: Энэ бүлэг асуултаар хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа нэгжийн бизнесээ эрхлэн явуулж байгаа хугацаа, ажлын байрны нөхцөл болон тухайн орон нутагт ямар нэгэн бүртгэлтэй эсэх, санхүүгийн тайлан хөтлөлт, зах зээлд бараа, үйлчилгээгээ борлуулдаг эсэх мэдээллийг цуглуулсан.

Бүлэг 4. Ажил эрхлэлт: Судалгаанд хамрагдаж байгаа нэгжид ажиллаж байгаа ажиллагчдын талаарх ерөнхий мэдээлэл (нэр, нас, хүйс, ажил эрхлэлтийн байдал)-ээс гадна гэрээ, ажилласан цаг, цалин зэрэгтэй холбоотой асуултууд тусгагдсан.

Бүлэг 5. Үйлдвэрлэлт, борлуулалт: Энэ бүлэг асуултаар тухайн нэгжийн үйлдвэрлэлт, борлуулалтын талаарх мэдээллийг гол нэрийн бараа бүтээгдэхүүн бүрээр, түүнчлэн нэгжийн үйлдвэрлэлт, сүүлийн 12 сарын үйл ажиллагааны түвшинг саруудаар гаргаж, цуглуулсан.

Бүлэг 6. Үйл ажиллагааны зардал: Энд дээрх бүлэг асуултын адилаар тухайн нэгжийн үйл ажиллагаанд гарсан түүхий эд, материалын зардал, борлуулсан барааны өртөг, бизнесийн үйл ажиллагаатай холбогдон гарах бусад зардлуудын талаарх асуултууд тусгагдсан.

Бүлэг 7. Хувийн орон сууц болон барилгын талаарх мэдээлэл: Энэ хэсэгт ХХЭН өөрийн хэрэгцээндээ зориулан барьсан орон сууц, тэдгээрийн өртгийн талаарх мэдээллийг цуглуулсан.

Судалгааны ярилцлага авагч нарт зориулсан гарын авлага нь танилцуулга; судалгааны үйл явц; судалгааны асуулгыг нөхөх зааврыг багтаасан 7 үндсэн бүлгээс бүрдсэн.

Судалгааны ахлагч, тоологч нарын сургалт

Ажлын хэсэг аймаг, дүүрэг, нийслэлд судалгааг зохион байгуулж явуулах сургагч багш, тоологч, ахлагчийг сонгон томилж, 2 шатны сургалтыг явуулсан

- 1) Аймаг, дүүргийн статистикийн хэлтсээс сонгодсон 34 сургагч багшийг оролцуулсан сургалтыг 2012 оны 7 сарын 16-18-нд өдрүүдэд ҮСХ-нд зохион байгуулсан.
- 2) ҮСХ-оос бэлтгэсэн судалгааны ахлагч/ сургагч багш нар тухайн орон нутгийн судалгааны тоологч, кодлогч болон мэдээлэл оруулагч нарт зориулнарт зориулан сургалтыг 2012 оны 7 дугаар сарын сүүлийн хагаст зохион явуулсан. Нийтдээ 78 судлаач хамрагдсан.

Мэдээлэл цуглуулалт

Судалгааны тоологч нар сонгогдсон өрхүүдэд очиж тухайн өрхийн ХХЭН-ээс шууд ярилцлага авах замаар мэдээллээ цуглуулсан. ХХЭН-ийн ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгч судалгаа авах явцад гэртээ байгаагүй тохиолдолд гэр бүлийн гишүүдтэй тохиролцон тухайн хүнийг гэртээ байх хугацаанд дахин ирж эсвэл тухайн хүн үйл ажиллагаагаа явуулж буй газар дээр нь очиж судалгааг авсан. Судалгааг авах үеэр өрх эзгүй байх тохиолдолд судалгаанд сонгогдсон өрхийг бүрэн хамруулахын тулд дахин очиж, судалгаанд хамруулах ажилд хяналт тавьж ажиллав. Үүний дүнд судалгааны туршид 2982 гаруй хувиараа хөдөлмөр эрхлэгчээс асуулга авч чадсан. Энэ нь нийт нэгжийн 99.2 хувь байсан.

Судалгааны мэдээлэл цуглуулах явцад хяналтыг ҮСХ, дүүргийн мэргэжилтнүүдээс бүрдсэн хяналтын баг 2012 оны 8 дугаар сарын 23-31-ны хооронд Сэлэнгэ аймаг болон нийслэлийн төвийн 6 дүүрэгт хянан, шалгаж, гарсан ололт, дутагдлыг тухай бүр нь танилцуулж, зохих арга хэмжээг авч ажилласан.

Мэдээлэл боловсруулалт

Мэдээллийг оруулах бүрдүүлэлтийн үе шат: Мэдээлэл оруулах үйл явц нь дараах дарааллаар хийгдсэн.


- Судалгааны ахлагч нар нь аймаг, нийслэлийн мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулж явуулсан.
- ХХЭС-ны мэдээллийг 2012 оны III улиралд цуглуулсан.
- Мэдээлэл цуглуулсны дараа нөхөгдсөн асуулгын хуудсыг ахлагч нар шалгаж байсан.
- Ахлагч нар нөхөгдсөн маягтыг кодлож, шалгасан.
- Тооллого, судалгааны мэдээлэл боловсруулдаг CPro 4.1 багц програмаар ХХЭС-ны мэдээллийг компьютерт шивж оруулах, шалгах, засварлах ажлыг хийсэн.

- CSPro хэлбэрт мэдээллийг оруулахад нийслэл, аймаг бүрт мэдээлэл оруулагч ажилласан. Зарим шууд автомат шалгалтуудыг CSPro програмд мэдээллийг оруулах үед хийсэн. Эдгээрт дээд, доод утгын шалгалт, асуулга хоорондын уялдаа холбооны шалгалт, мэдээлэл дутуу оруулсан тохиолдолд цааш нь оруулж болохгүй саатуулах, асуулгын хариулт нь логик уялдаа холбоогүй байгааг урдаас сануулах зэрэг шалгалтууд орсон. Иймээс ахлагч нар асуулга бүрэн эсэх, үсрэлт үнэн эсэх үнэмшилтэй утга зэргийг шалгаж ажилласан.
- Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газар (ХХЭС-ны) CSPro программд програмын алдаагүй болсон мэдээллийн файлаа ҮСХ-нд ирүүлж байсан. Дараагийн шатны нэгтгэл, хяналт, шалгалтыг хийж, засварлах ажлыг ҮСХ-нд хийж гүйцэтгэсэн.


Мэдээллийн чанарыг дахин хянах, боломжит алдаа, тохиолдол болон шийдлүүдийг тодорхойлох, дарааллын болон уялдаа холбооны шалгалтыг хийх зааварчилгааг боловсруулсан. Зааварчилгааны дагуу өрхөөс ярилцлага авч, цуглуулсан мэдээллийг зааврын дагуу шалгаж, кодлон компьютерт шивж оруулж, шалгаж, засварлан ҮСХ-нд дамжуулах ажлыг аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрын ХХЭС-ны баг хийж, дараагийн шатны хяналт, шалгалтыг хийж, засварлах ажлыг ҮСХ-нд хийж гүйцэтгэсэн.

Судалгааны мэдээлэл боловсруулах системийн ерөнхий зарчим нь дараах 2 үе шаттайгаар явагдсан.

ЗУРАГ 2.2. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС, ГАЗАРТ МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАХ СХЕМ



ЗУРАГ 2.3. ҮСХ-НД МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАХ СХЕМ



Мэдээллийг засварлаж дууссаны дараа аймаг, нийслэлийн статистикийн хэлтсээс ҮСХ-нд дамжуулсан. ҮСХ-нд мэдээллийг дахин шалгаж, уялдаа холбооны нэмэлт шалгалтыг хийж, алдааны жагсаалтыг аймаг, нийслэл рүү явуулсан. Үүний дараа аймаг, нийслэлийн судалгааны баг дахин засварлан ҮСХ-нд ирүүлсэн. Эцэст нь бүх аймаг, нийслэлээс ирсэн мэдээллийг нэгтгэж хүснэгт гаргах үе шатанд бэлэн болгосон.

Мэдээллийг засварлах үе шат

Мэдээллийг засварлах үйл явц нь алдааг олж, тодорхойлох, алдааг засварлах гэсэн хоёр үе шатаас бүрдэж байсан юм.

Алдааг олж илрүүлэхэд дараах шалгалт автомат хийгдсэн. Үүнд:

Тооллогын асуулгад хөдөө аж ахуй эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын талаарх мэдээллийг нас, хүйс, боловсролын түвшин, ажилласан жил, тухайн байгууллагыг удирдсан жил, үүсгэн байгуулагчийн тоо гэсэн үзүүлэлтүүдээр цуглуулж үр дүнг мөн нэгтгэв.

- **Ердийн шалгалт:** бүх асуулт бүрэн хариулагдсан эсэхийг шүүж шалгах, үсрэлт зөв байгааг шалгах шалгалт;
- **Үнэмшилтэй утгийн шалгалт:** байж болох утгаас давсан онцгой утга байгаа эсэхийг шалгах шалгалт;
- **Статистик анализд тулгуурлагдсан хамаарлын болон логик шалгалт:** утгуудын хоорондын уялдаа, логик холбоо, утгуудын нийлбэр нийт дүнтэй тэнцүү эсэх шалгалт;
- **Мэдээлэл оруулах програмын шалгалт:** үүнд ердийн шалгалт, үнэмшилтэй утга болон хамаарлын шалгалтууд;
- **Мэдээлэл шалгах програмын шалгалт:** Мэдээлэл оруулах програмын шалгалт, дээр нь нэмэлт шалгалтууд;

Ердийн шалгалт нь мэдээлэл оруулах түвшинд (Тооллого, судалгааны мэдээлэл боловсруулдаг CPro 4.1 багц програмаар) бэлтгэгдсэн байсан. Эдгээр ердийн шалгалт нь мэдээллийн алдааг шууд хянасан. Энэ нь ярилцлага авагч нар алдаа гарсан тохиолдолд эргэн холбогдож, алдааг залруулах боломжтой байсан. Хэдий тийм боловч зарим боломжит шалгалтууд орхигдсон байсан.

Эхний үе шатанд алдааг гурван бүлэгт ангилж авч үзсэн. Үүнд:

- Мэдээлэл оруулах үеийн алдаа. Програмд оруулсан утга нь ярилцлага авагчийн маягтан дээр бичсэн утгаас өөр байх тохиолдол;
- Мэдээллийг компьютерт зөв оруулсан боловч мэдээллийг шалгаж буй ажилтан тухайн маягтын бусад асуултуудын хариулттай уялдуулан шалгахад логик уялдаагүй асуудал гарсан тохиолдол;
- Мэдээллийг компьютерт зөв оруулсан ба логик уялдаагүй зүйл байхгүй ЭСВЭЛ мэдээллийг компьютерт зөв оруулсан ба маягтын бусад асуултуудын хариулттай тулгаж уялдуулан шалгахад засвар хийх боломжгүй логик уялдааны асуудал байгаа тохиолдол.

Дээрх алдааг тодорхойлсны дараа бүх нөхөгдсөн маягтыг шалгаж, эхний хоёр төрлийн алдааны хувьд зохих засваруудыг хийсэн.

Мэдээллийн чанарын үнэлгээ

Судалгааны мэдээллийг шалгаж, холбогдох засварыг хийсний дараа судалгааны мэдээллийн чанарыг дараах үзүүлэлтүүдээр дахин үнэлсэн.

Үүнд:

- Засагдаагүй үлдсэн алдааны тохиолдлууд (шалгалтын үр дүнгээр маягтан дээр нөхөгдсөн утгын болон асуулгын бусад асуултуудтай уялдуулан зассаны дараа үлдсэн алдааны тохиолдлууд);
- Орхигдсон судалгааны нэгжүүд (АХС-ны судалгааны мэдээллээр ХХЭС-нд хамрагдах ёстой байсан боловч судалгаанд хамрагдаагүй нэгжүүд);
- Зайлшгүй шаардлагатай үзүүлэлтүүдийн орхигдсон, хэт бага болон их утгууд.

ХХЭС-наас нэмэгдэл өртгийн тооцоо болон албан бус бизнес эрхлэгчдийн талаарх хувьсагчдыг шалгасан. Үүнд:

- Бизнесийн төлөв байдлын талаарх үзүүлэлтүүд;
- ХХЭН дэх ажил эрхлэлтийн талаарх үзүүлэлтүүд;
- Нэмэгдэл өртгийг тооцоход оролцох үзүүлэлтүүд.

Орхигдсон утгыг тооцож орлуулсан арга зүй

Судалгааны мэдээллийн чанарыг үнэлж орхигдсон утгыг тооцож орлуулахдаа дараах ерөнхий зарчмыг баримталсан. Үүнд:

- Тооцож орлуулсан утга нь бодит утгаас зөрүүтэй байх учир бүх орхигдсон утгыг тооцож орлуулахаас зайлсхийх;
- Нэмэлт мэдээллүүдийг боломжит түвшинд ашиглах. Тухайлбал, борлуулалтын хэмжээ орхигдсон тохиолдолд ХХЭН-ий ажиллагчдын тоо, үйл ажиллагааны төрөл, улирлын хэлбэлзэл зэрэг мэдээллийг ашиглах.

Түүврийн хэмжээ N ба R0 тооны судалгааны нэгжийн хувьд X0 хувьсагчийн утга орхигдсон бол N-R0 тооны судалгааны нэгжийн хувьд бүрэн нөхөгдсөн байна. Орхигдсон утгыг тооцож орлуулах нь тухайн хувьсагч орхигдоогүй тохиолдолд ямар утгатай байх ёстой байсныг тооцох зорилготой юм.

Орхигдсон утгыг тооцож орлуулахдаа дараах хоёр төрлийн мэдээллийг ашигласан. Үүнд:

- Бүрэн мэдээлэгдсэн нэмэлт мэдээллийг ашиглах ($X_1..X_n$) (бүх N судалгааны нэгжийн хувьд бүрэн нөхөгдсөн үзүүлэлтүүд);
- $(N-R_0)$ тооны судалгааны нэгжийн дэд олонлогийн хувьд X_0 утгыг тооцох.

X_0 хувьсагчийн төрөл тоон эсвэл чанарын эсэх, бүрэн мэдээлэгдсэн нэмэлт мэдээлэл ($X_1..X_n$), мэдээлэл дэх орхигдсон утгын эзлэх хувийн жин (R_0/N) зэргээс шалтгаалан орхигдсон утгыг тооцож орлуулах аргыг сонгож хэрэглэсэн.

Чанарын хувьсагчдын хувьд орхигдсон утгыг тооцож орлуулахдаа Эконометрикийн шугаман бус регресс, “Хоот дек” гэсэн хоёр төрлийн аргыг голчлон ашигласан.

Тоон хувьсагчдын хувьд Эконометрикийн шугаман регресс, “Хоот дек”, бүлгийн медиан (эсвэл дундаж)-ыг ашиглах гэсэн гурван төрлийн аргыг хэрэглэсэн.

ХХЭС-ны шаардлагатай хувьсагчид орлуулга хийсэн байдал

Нэмэгдэл өртөг:

Нэмэгдэл өртөг нь нийт үйлдвэрлэлт болон завсрын хэрэглээний зөрүүгээр илэрхийлэгдэнэ.

Нэмэгдэл өртөг = Нийт үйлдвэрлэлт - Завсрын хэрэглээ

Сарын нэмэгдэл өртөг сөрөг утгатай гарсан ХХЭН-ийг ижил шинж чанараар нь 4 бүлэгт хуваан авч үзсэн..

I. Бизнесийн үйл ажиллагаанд байж болох /орлого, өртгийн харьцаа, бизнесийн хэмжээ зэргийг харьцуулахад сөрөг нэмэгдэл өртөгтэй байж болох/.
Энэ тохиолдолд ямар нэг өөрчлөлт хийхгүй хэвээр нь үлдээнэ.

II. Завсрын хэрэглээ буруу бол орлуулга хийнэ

III. Нийт орлого буруу бол орлуулга хийнэ.

IV. Өгсөн хариултын чанар нь хэтэрхий муу

II, III бүлэгт орсон ХХЭН-ийн нэмэгдэл өртгийг дахин үнэлсэн

II бүлэгт байгаа тохиолдолд завсрын хэрэглээг, III тохиолдолд завсрын хэрэглээ болон нийт орлогын харьцааг хэрэглэн, “Хоот дек”-ийн аргаар нийт орлогыг үнэлсэн.

Үр дүнгийн хүснэгтүүдийг бэлтгэсэн талаар

Мэдээллийн алдааг шалгаж, холбогдох засвар өөрчлөлтийг хийж, орхигдсон шаардлагатай утгыг тооцож орлуулсны дараа алдаагүй болсон мэдээллийн санг ашиглан үр дүнгийн хүснэгтүүдийг бэлтгэсэн.

Хувиараа хөдөлмөр эрхлэлтийн судалгааны түүврийн тархаалт нь АХС-ны түүвэрлэлт, судалгаагаар цуглуулагдсан мэдээллийн үр дүнгээс шалтгаалан хийгдсэн. Судалгааны үр дүнгийн хүснэгтүүдийг бэлтгэхдээ SPSS 15 програмыг ашигласан.

Судалгааг явуулснаар тоон болон чанарын дараах үндсэн хоёр төрлийн мэдээллийг гарган авсан. Үүнд:

1. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн тоо;
2. Хувиараа хөдөлмөр эрхлэгч нэгжүүдийн бий болгож буй нэмэгдэл өртгийн хэмжээ;

Судалгааны дүн

Хувиараа хөдөлмөр эрхлэгч нэгжийн тоо, тэдний бизнесийн үйл ажиллагааны төлөв байдал

Энэхүү бүлэгт хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа нэгжийн тухайн бизнесийг эрхлэн явуулж байгаа хугацаа, ажлын байрны нөхцөл болон тухайн орон нутагт ямар нэгэн бүртгэлтэй эсэх, санхүүгийн тайлан хөтлөлт, зах зээлд бараа, үйлчилгээгээ борлуулдаг эсэх мэдээллүүд хамрагдаж байгаа юм.

Судалгааны дүнгээс үзвэл 163.6 мянган нэгж үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний чиглэлээр хувиараа хөдөлмөр эрхэлж байна. Үүнээс 129.5 мянган нэгж буюу 79.1 хувь нь хотод, 34.1 мянган нэгж буюу 20.9 хувь нь хөдөөд үйл ажиллагаагаа явуулж байна.

Хувиараа хөдөлмөр эрхэлж буй нэгжийн тоог салбарын бүтцээр авч үзвэл 18.2 хувь нь үйлдвэрлэл, 8.0 хувь нь барилга, 44.0 хувь нь худалдаа, 29.8 хувь нь үйлчилгээ эрхэлж байна. Үйлчилгээний салбарт тээврийн үйл ажиллагаа эрхлэгчид 66.1 хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 2.1. ХХЭН-ИЙН ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байршлаар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	БҮГД		үүнээс:			
	Тоо	%	Хот		Хөдөө	
			Тоо	%	Тоо	%
Бүгд дүн	163 636	100.0	129 490	79.1	34 146	20.9
Боловсруулах үйлдвэр	28 914	17.7	18 868	11.5	10 046	6.1
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэгээ	790	0.5	327	0.2	463	0.3
Барилга	13 073	8.0	11 506	7.0	1 567	1.0
Бөөний, жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	72 055	44.0	60 119	36.7	11 936	7.3
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	32 288	19.7	26 108	16.0	6 180	3.8
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	3 667	2.2	2 242	1.4	1 425	0.9
Бусад үйлчилгээ	12 849	7.9	10 320	6.3	2 529	1.5


Хувиараа хөдөлмөр эрхлэгч нийт нэгжийн 23.7 мянга буюу 14.5 хувь нь баруун бүсэд, 30.4 мянга буюу 18.5 хувь нь хангайн бүсэд, 22.7 мянга буюу 13.9 хувь нь төвийн бүсэд, 7.7 мянга буюу 4.7 хувь нь зүүн бүсэд, 79.2 мянга буюу 48.4 хувь нь Улаанбаатар хотод тус тус үйл ажиллагаа явуулж байна.

ХҮСНЭГТ 2.2. ХХЭН-ИЙН ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, бүсээр

БҮС	Нийт ХХЭН-ийн тоо	Эдийн засгийн үйл ажиллагааны салбар						
		Боловсруулах үйлдвэр	Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэгээ	Барилга	Бөөний, жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	Үйлчилгээ
Бүгд дүн	163 636	28 914	790	13 073	72 055	32 288	3 667	12 849
Баруун бүс	23 691	5 125	42	898	11 033	4 505	849	1 240
Хангайн бүс	30 363	7 058	239	2 600	12 844	5 082	669	1 871
Төвийн бүс	22 726	3 853	190	861	10 159	4 764	815	2 085
Зүүн бүс	7 689	1 589	168	689	2 932	1 458	238	615
Улаанбаатар	79 167	11 289	150	8 027	35 089	16 478	1 096	7 038


Хувиараа хөдөлмөр эрхлэгч нийт нэгжийн 48.3 хувь нь нийслэлд, 31.7 хувь нь аймгийн төвд, 18.6 хувь нь сумын төвд, 1.4 хувь нь хөдөө үйл ажиллагаагаа явуулж байна.

ЗУРАГ 2.4. ХХЭН-ИЙН ТООНЫ СУУРЬШЛИЙН БҮТЭЦ (%)



Хувиараа хөдөлмөр эрхлэгч өрхийн ам бүлийн дундаж тоо 4.1 байгаа ба 10.1 хувь нь 1-2 ам бүлтэй, 20.6 хувь нь 3 ам бүлтэй, 33.1 хувь нь 4 ам бүлтэй, 22.6 хувь нь 5 ам бүлтэй, 13.5 хувь нь 6-аас дээш ам бүлтэй байна. Энэ үзүүлэлтээс харахад хувиараа хөдөлмөр эрхлэгч нэгжид бий болж буй орлого 700 мянга орчим хүний амжиргааны эх үүсвэр болж байна гэж үзэж болох юм.

ЗУРАГ 2.5. ХХЭН-ИЙН ЭЗНИЙ АМ БҮЛИЙН ТОО



Хувиараа хөдөлмөр эрхлэгч нэгжийн эзний нас, хүйсийн бүтцийг авч үзвэл 77.4 хувь нь 25-49 насных, 59.6 хувь нь эрэгтэй, 40.4 хувь нь эмэгтэй байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгчид нь бие даан дангаараа, эсвэл гэр бүлийн гишүүдтэйгээ хамтран, эсвэл гаднаас ажилтан хөлсөлж үйл ажиллагаа явуулж байна. Нийт хувиараа хөдөлмөр эрхлэгч нэгжийн 87.5 хувь нь дангаараа, 11.3 хувь нь 2-5 ажиллагчтай, 1.2 хувь нь 6-аас дээш ажиллагчтай байна.

ХХЭН-ийн үйл ажиллагаа явуулсан хугацаанаас хэр тогтвортойг нь харж болно. Судалгааны дүнгээр нийт ХХЭН-ийн 40.4 хувь нь 5 хүртэлх жил, 7.8 хувь нь 6 жил, 5.8 хувь нь 7 жил, 46.0 хувь нь 8-аас дээш жил үйл ажиллагаа явуулж байна.

ХҮСНЭГТ 2.3. ХХЭН-ИЙН ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, үндсэн үзүүлэлтүүдээр

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Нийт ХХЭН	Ажиллагчдын тооны бүлэг				Эзний хүйс	
		1	2-5	6-9	10+	Эр	Эм
Бүгд дүн	163 636	143 129	18 474	1 738	295	97 590	66 046
Боловсруулах үйлдвэр	28 914	24 837	3 600	416	61	15 589	13 325
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэгээ	790	790	-	-	-	674	115
Барилга	13 073	11 254	1 606	167	46	9 947	3 126
Бөөний, жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	72 055	62 746	8 405	759	145	33 917	38 139
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	32 288	30 531	1 757	-	-	30 661	1 627
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	3 667	1 626	1 767	231	43	720	2 947
Бусад үйлчилгээ	12 849	11 345	1 339	165	-	6 082	6 767

Нийт дүнд эзлэх хувь **100.0** **87.5** **11.3** **1.1** **0.1** **59.6** **40.4**

хүснэгт 2,3 -ийн үргэлжлэл

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Ажлын байр		Үйл ажиллагаагаа эхэлсэн он					
	Тогтсон ажлын байргүй	Тогтсон ажлын байртай	2005-	2006	2007	2008	2009	2010+
Бүгд дүн	80 287	83 349	75 257	9 520	12669	16073	15347	34 770
Боловсруулах үйлдвэр	21 680	7 234	15 110	1 424	2 178	2 929	2 264	5 009
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэгээ	498	292	204	-	50	42	206	288
Барилга	11 564	1 509	7 203	804	1 241	980	1 180	1 665
Бөөний, жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	13 957	58 098	34 111	4 401	4 809	6 957	6 966	14 811
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	27 266	5 022	10 857	2 264	3 199	3 745	3 230	8 993
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	629	3 038	1 646	126	159	352	383	1 001
Бусад үйлчилгээ	4 693	8 156	6 126	501	1 033	1 068	1 118	3 003

Нийт дүнд эзлэх хувь **49.1** **50.9** **46.0** **5.8** **7.8** **9.8** **9.4** **21.2**

Хувиараа хөдөлмөр эрхэлж буй нэгжийн 95.9 хувь нь энэ үйл ажиллагааг үндсэн үйл ажиллагаа, 4.1 хувь нь хоёрдогч үйл ажиллагаа байдлаар эрхэлж байна. Үйлдвэрлэлийн салбарт хоёрдогч үйл ажиллагааг хамгийн их буюу 2620 нэгж эрхэлж байна.

ХҮСНЭГТ 2.4. ХХЭН-ИЙН ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, үндсэн ба хоёрдогч үйл ажиллагаагаар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Нийт ХХЭН	үүнээс:	
		Үндсэн үйл ажиллагаа	Хоёрдогч үйл ажиллагаа
Бүгд дүн	163 636	156 937	6 699
Боловсруулах үйлдвэр	28 914	26 294	2 620
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэгээ	790	790	-
Барилга	13 073	12 762	311
Бөөний, жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	72 055	70 419	1 636
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	32 288	31 130	1 158
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	3 667	3 453	214
Бусад үйлчилгээ	12 849	12 089	760
Нийт дүнд эзлэх хувь	100.0	95.9	4.1

Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн үйл ажиллагааны тогтвортой байдал, цар хүрээг харуулдаг нэг үзүүлэлт бол ажлын байр юм.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч нэгжийн 49.1 хувь нь тогтсон ажлын байргүй буюу гудамж, зам дагуу түр хугацаагаар байрлуулсан цэг, хогийн цэг, үйлчлүүлэгч, хэрэглэгчийн гэрт, өөрийн гэрт зэрэгт, харин 50.9 хувь нь тогтсон ажлын байртай буюу дэлгүүр, үйлчилгээний төв, гуанз, зоогийн газар зэрэгт үйл ажиллагаагаа явуулж байна.

Албан бус секторт үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн тал хувь нь гэртээ, тусгай тоног төхөөрөмжтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг байна.

ХҮСНЭГТ 2.5. ХХЭН-ИЙН ТОО, ажлын байрны төрлөөр


Ажлын байр	Эдийн засгийн үйл ажиллагааны салбар						
	БҮГД		Боловруулах үйлдвэр	Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэгээ	Барилга	Бөөний, жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	Үйлчилгээ
	Тоо	%	Тоо	Тоо	Тоо	Тоо	Тоо
Бүгд дүн	163 636	100.0	28 914	790	13 073	72 055	48 804
Тогтсон ажлын байргүй	80 288	49.1	21 680	498	11 565	13 957	32 588
Гудамжинд/хөдөлгөөнтэй	4 317	2.6	118	180	304	2 949	766
Зам дагуу түр хугацаагаар байрлуулсан цэгт	3 459	2.1	156	-	-	2 745	558
Тээврийн хэрэгсэлд	26 506	16.2	-	114	-	461	25 931
Үйлчлүүлэгч, хэрэглэгчийн гэрт	9 701	5.9	815	-	7 698	443	745
Гэртээ, тусгай тоног төхөөрөмжгүй	7 888	4.8	5 087	-	-	1 656	1 145
Хогийн цэг дээр	243	0.1	-	-	-	243	-
Үзвэрийн газарт	60	0.0	-	-	-	-	60
Бусад	6980	4.3	1104	204	3563	1325	784
Тогтсон ажлын байртай	83 348	50.9	7 234	292	1 508	58 098	16 216
Дэлгүүр, зах, үйлчилгээний төвд (мухлаг, лангуу, чингэлэг)	57 060	34.9	2 771	63	159	50 736	3 331
Засварын газар, үйлчилгээний төв, дэлгүүр, гуанз, зочид буудалд	14 138	8.6	2 151	-	109	5 857	6 021
Зохион байгуулалттай такси болон авто зогсоол/ нийтийн тээврийн хэрэгсэлд	4 405	2.7	54	-	-	135	4 216
Бусад	7 745	4.7	2 258	229	1 240	1 370	2 648

Ажил эрхлэлт

Энэ хэсэгт судалгаанд хамрагдаж байгаа нэгжид ажиллаж байгаа ажиллагчдын талаарх ерөнхий мэдээлэл (нэр, нас, хүйс, ажил эрхлэлтийн байдал)-ээс гадна гэрээний төрөл, ажилласан цаг, цалин зэрэгтэй холбоотой асуултууд тусгагдсан.

ХХЭН-д 209.9 мянган иргэн ажиллаж байна. Нийт ажиллагчдын 68.0 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 16.6 хувь нь цалинтай ажиллагч, 9.9 хувь нь ажил олгогч, 4.6 хувь нь гэр бүлийн бизнест цалингүй оролцогч, 0.7 хувь нь хамтран ажиллагч, 0.2 хувь нь цалинтай дадлагажигч байна.

ЗУРАГ 2.6. ХХЭН-Д АЖИЛЛАГЧДЫН ТОО, ажил эрхлэлтийн байдлын, бүтэцээр



ХХЭН-д ажиллагчдын 9.1 хувь нь 15-24 насны, 89.2 хувь нь 25-60 насны, 1.7 хувь нь 61-ээс дээш насны хүмүүс байна.


Ажиллагчдаа ажилд авсан байдлыг авч үзвэл 60.5 хувь нь төрөл садан, найз нөхдөө авч ажилуулсан, 23.2 хувь нь нэгжийн эзэнтэй шууд холбогдож, 7.0 хувь нь зар сурталчилгаагаар, 6.2 хувь нь зуучлуулах замаар, 3.1 хувь нь бусад замаар ажилд оржээ.

ХХЭН-д ажиллагчдын гэрээний төрлийг нь авч үзвэл тогтсон хугацаагүй бичгээр үйлдсэн гэрээ 7.6 хувь, тогтсон хугацаатай бичгээр үйлдсэн гэрээ 9.6 хувь, аман гэрээ 44.2 хувь, гэрээгүй 38.6 хувь байна. Эндээс үзэхэд албан бус секторт ажил олгогч нь ихэвчлэн төрөл садан, найз нөхдөө ажилд авч, гэрээгүй ажиллуулдаг байна.

54.4 хувь нь сар/долоо хоногоор тогтоосон цалин, 25.0 хувь нь гүйцэтгэсэн ажлаар нь, 12.0 хувь нь цагаар, 8.6 хувь нь урамшууллын хэлбэрээр цалин олгодог байна.

ХХЭН-д ажиллагчид сард дунджаар 202 цаг, үүнээс эрэгтэйчүүд 191 цаг, эмэгтэйчүүд 213 цаг ажилласан байна. Энэ үзүүлэлт байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагааны салбарт хамгийн их буюу 235 цаг, боловсролын салбарт хамгийн бага буюу 116 цаг байна. Албан бус секторт ажиллагчдын 23.9 хувь нь 201-250 цаг, 22.6 хувь нь 151-200 цаг, 16.9 хувь нь 251-300 цаг, 16.9 хувь нь 100-аас бага цаг, 12.5 хувь нь 101-150 цаг, 7.2 хувь нь 301-ээс дээш цаг ажиллаж байна.

ЗУРАГ 2.7. ХХЭН-Д АЖИЛЛАГЧДЫН ТОО, сард ажилласан цагийн бүтцээр



Ажиллагчдын сарын дундаж цалин 312.8 мянган төг байна. Барилгын салбарт ажиллагчдын дундаж цалин хамгийн өндөр буюу 487.8 мянган төг, хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагааны салбарт ажиллагчдын дундаж цалин хамгийн бага буюу 117.7 мянган төг байна.

ХҮСНЭГТ 2.6. ХХЭН-Д АЖИЛЛАГЧДЫН ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Нийт ажиллагчдын тоо	Ажиллагчдын насны бүлэг			Сард ажилласан дундаж цаг	Сарын дундаж цалин (төгрөг)
		15-24	25-60	61+		
Бүгд дүн	209 916	19 185	187 297	3 434	202	312 829
Боловсруулах үйлдвэр	39 374	3 810	34 830	734	193	297 629
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэгээ	790	-	739	51	200	-
Барилга	18 389	2 012	16 287	90	183	487 807
Бөөний, жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	91 835	6 777	83 226	1 832	212	299 213
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	34 325	2 559	31 447	319	162	252 584
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	9 261	2 049	7 212	-	235	257 615
Бусад үйлчилгээ	15 943	1 978	13 557	408	163	236 632
Нийт дүнд эзлэх хувь	100.0	9.1	89.2	1.7		
Хүйс:						
Эр	120 880	11 676	107 407	1 797	191	352 497
Эм	89 036	7 509	79 890	1 637	213	272 004


ХХЭН дэх нийт ажиллагчдын 28.1 мянга буюу 13.4 хувь нь баруун бүсэд, 36.3 мянга буюу 17.3 хувь нь хангайн бүсэд, 29.8 мянга буюу 14.2 хувь нь Төвийн бүсэд, 12.8 мянга буюу 6.1 хувь нь зүүн бүсэд, 102.8 мянга буюу 49.0 хувь нь Улаанбаатар хотод ажиллаж байна.

ХҮСНЭГТ 2.7. ХХЭН-Д АЖИЛЛАГЧДЫН ТОО, бүсээр

Бүс	Нийт ажиллагчдын тоо	Ажиллагчдын насны бүлэг			Ажил эрхлэлтийн байдал			
		15-24	25-60	61+	Эзэн/ажил олгогч	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	Цалинтай ажиллагч	Гэр бүлийн бизнест цалингүй оролцогч
Бүгд дүн	209 916	19 185	187 297	3 434	20 841	142 795	35 248	11 032
Баруун бүс	28 135	2 537	24 874	724	2 254	21 438	3 768	676
Хангайн бүс	36 338	2 498	33 351	489	2 715	27 648	5 810	165
Төвийн бүс	29 807	2 633	26 684	489	2 687	20 039	5 828	1 253
Зүүн бүс	12 841	1 324	11 398	118	2 544	5 145	2 935	2 217
Улаанбаатар	102 796	10 193	90 990	1 613	10 642	68 525	16 907	6 721

Нэг ажиллагчийн сарын дундаж цалин Улаанбаатар хотод хамгийн их буюу 373.8 мянган төг, баруун бүсэд хамгийн бага буюу 200.1 мянган төг байна.

ЗУРАГ 2.8. ХХЭН-Д АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН (төгрөг), бүсээр



Хувиараа хөдөлмөр эрхлэгч нийт нэгжийн 17.0 хувь нь долоо хоногт 24-өөс бага цаг, 19.2 хувь нь 24-40 цаг, 21.3 хувь нь 41-50 цаг, 42.5 хувь нь 51 ба түүнээс дээш цаг ажилладаг нь харагдаж байна. Нийслэлд хөдөөг бодвол илүү урт хугацаагаар ажилладаг байна. Харин хөдөө орон нутгийнхтай харьцуулахад хот, суурин газарт эрэгтэйчүүд үйл ажиллагаа эрхлэхэд илүү их цагийг зарцуулж байхад эмэгтэйчүүдийн хувьд эсрэгээрээ буюу хөдөө орон нутагт илүү цагийг зарцуулж байна.

ХҮСНЭГТ 2.8. ХХЭН-Д АЖИЛЛАГЧДЫН 7 ХОНОГТ АЖИЛЛАСАН ХУГАЦАА, суурьшлаар (%)

7 хоногт ажилласан хугацаа	БҮГД	Суурьшил			
		Нийслэл	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө
Бүгд дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0
24 цагаас бага	17.0	17.5	14.8	18.8	30.9
24- 34 цаг	9.4	8.8	10.6	8.7	12.5
35- 40 цаг	9.8	9.7	10.7	9.2	4.5
41- 50 цаг	21.3	20.8	21.1	24.0	10.9
51 цагаас их	42.5	43.3	42.8	39.4	41.2


Долоо хоногт ажилласан дундаж хугацаа байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагааны салбарт хамгийн их 52.8 цаг, худалдааны салбарт 49.2, барилгын салбарт 46.2 цаг байна.

ХҮСНЭГТ 2.9. ХХЭН-Д АЖИЛЛАГЧДЫН 7 ХОНОГТ ДУНДАЖ АЖИЛЛАСАН ЦАГ, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, суурьшлаар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	БҮГД	Суурьшил			
		Нийслэл	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө
Бүгд дүн	46.1	46.7	45.9	45.0	46.6
Боловсруулах үйлдвэр	40.8	44.8	40.1	37.0	31.8
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэгээ	44.8	61.6	50.3	35.5	-
Барилга	46.2	46.6	43.9	48.6	67.7
Бөөний, жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	49.2	47.5	50.2	52.7	56.8
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	44.7	47.6	42.9	39.9	47.1
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	52.8	53.2	45.2	55.8	67.2
Бусад үйлчилгээ	40.4	41.3	37.6	41.8	33.9

ХХЭН-д худалдааны салбар нь ажил эрхлэлтийн үндсэн салбар болж байгаа бөгөөд хоёрдугаарт үйлчилгээний салбар орж байна. Нийт ажиллагчдын 43.7 хувь нь худалдааны салбарт, 28.3 хувь нь үйлчилгээний салбарт, 27.9 хувь нь үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байна.

ЗУРАГ 2.9. ХХЭН-Д АЖИЛЛАГЧДЫН ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хот, хөдөө, хүйсээр (%)



Ажил эрхлэлтийн салбарын бүтэц нь хот, хөдөөд эрс ялгаатай байна. Хотод нийт ажиллагчдын бараг хоёрны нэг нь худалдааны салбарт, гуравны нэг нь үйлчилгээний салбарт, үлдсэн нь үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байна. Харин хөдөөд үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарт тэнцүү хувьтай байна.

ХХЭН-д ажиллагчдыг хүйсээр авч үзвэл 120.9 мянга буюу 57.6 хувь нь эрэгтэй, 89.0 мянга буюу 42.4 хувь нь эмэгтэй байна. Тээврийн салбарт 94.4 хувь, барилгын салбарт 78.9 хувийг эрэгтэй ажиллагчид эзэлж байна. Харин хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагааны салбарт эмэгтэй ажиллагчдын эзлэх хувь хамгийн өндөр 100 хувь, байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагааны салбарт 86.3 хувь байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч нэгжийн бүрдүүлж буй нийт борлуулалт, нийт үйлдвэрлэлт, завсрын хэрэглээ, нэмэгдэл өртөг

ХХЭН-ийн сүүлийн 12 сарын борлуулалтын орлогын түвшин, сүүлийн сарын борлуулалтын орлогын талаарх мэдээлэлд үндэслэн жилийн борлуулалтын орлогын нийт хэмжээг тодорхойлсон.

Судалгааны дүнгээр хувиараа хөдөлмөр эрхлэгчид жилдээ 2799.2 тэрбум төгрөгийн борлуулалт хийдэг гэсэн дүн гарч байна.

ХХЭН-үүдийн олсон орлогын 68.2 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт, 15.2 хувь нь тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарт, 6.8 хувь нь үйлдвэрлэлийн салбарт, 3.7 хувь барилгын салбарт, 2.5 хувь нь байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагааны салбарт, 3.6 хувь нь бусад салбаруудад ногдож байна.

ХҮСНЭГТ 2.10. ХХЭН-ИЙН ТОО, ЖИЛИЙН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	ХХЭН-ийн тоо	Борлуулалтын орлого (сая төг)	Нэг нэгжид ногдох борлуулалтын орлого (мян.төг)	Нийт борлуулалтын орлогын дүнд эзлэх салбаруудын хувь
Бүгд дүн	163 636	2 799 189.2	17 106.1	100.0
Боловсруулах үйлдвэр	28 914	188 655.1	6 524.6	6.7
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэгээ	790	1 175.9	1 489.0	0.0
Барилга	13 073	104 405.5	7 986.1	3.7
Бөөний, жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	72 055	1 908 568.8	26 487.5	68.2
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	32 288	426 104.1	13 197.0	15.2
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	3 667	68 900.1	18 790.7	2.5
Бусад үйлчилгээ	12 849	101 379.7	7 890.2	3.6

Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ болон санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбарын хувиараа хөдөлмөр эрхлэгч нэг нэгжийн жилийн дундаж борлуулалтын орлого хамгийн өндөр буюу 26.5-31.8 сая төгрөг байна. Харин хүн хөлслүүлэн ажиллуулдаг өрхийн

үйл ажиллагаа, усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа, захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, боловсрол, хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагааны салбарт хамгийн доогуур буюу 0.8-5.8 сая төгрөг байна. Энэ нь уг салбарт хувиараа хөдөлмөр эрхлэгчид уг үйл ажиллагааг нэмэлт орлогын эх үүсвэр болгон хоёрдогч үйл ажиллагаа байдлаар эрхэлж буйтай холбоотой юм.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч нэг нэгжийн жилийн дундаж борлуулалтын орлогын хэмжээ 17.1 сая төг байгаа бөгөөд уг үзүүлэлтийг аймгуудаар авч үзвэл 2.3-21.1 сая төг-ийн хооронд хэлбэлзэж байна. Ховд, Орхон аймаг болон Улаанбаатарт хувиараа хөдөлмөр эрхлэгч нэг нэгжийн жилийн дундаж борлуулалтын орлого хамгийн өндөр буюу 20.0-21.1 сая төгрөг байсан бол Говьсүмбэр аймагт хамгийн бага буюу 2.3 сая төгрөг байна. Ховд аймагт худалдааны салбарт энэ үзүүлэлт хамгийн өндөр байна.

ХҮСНЭГТ 2.11. ХХЭН-ИЙН ТОО, ЖИЛИЙН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, бүсээр

Бүс	ХХЭН-ийн тоо	Борлуулалтын орлого (сая төг)	Нэг нэгжид ногдох борлуулалтын орлого (мян.төг)	Нийт борлуулалтын орлогын дүнд бүсийн эзлэх хувь
Бүгд дүн	163 636	2 799 189.2	17 106.1	100.0
Баруун бүс	23 691	334 506.3	14 119.3	12.0
Хангайн бүс	30 363	416 283.2	13 710.4	14.9
Төвийн бүс	22 726	355 296.4	15 633.8	12.7
Зүүн бүс	7 689	77 960.6	10 139.2	2.8
Улаанбаатар	79 167	1 615 142.7	20 401.6	57.7

Хувиараа хөдөлмөр эрхлэгч нэгжүүд жилдээ 1018.6 тэрбум төгрөгийн нэмэгдэл өртгийг бий болгож байна. Нийт нэмэгдэл өртгийн 17.2 хувийг үйлдвэрлэлийн салбар, 54.9 хувийг худалдааны салбар, 27.9 хувийг үйлчилгээний салбар бүрдүүлж байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны үр ашгийн түвшинг илтгэн харуулах үзүүлэлтийн нэг нь нэмэгдэл өртөг, нийт үйлдвэрлэлтийн харьцаа байдаг бөгөөд хувиараа хөдөлмөр эрхлэгч нэгжүүдийн хувьд энэ үзүүлэлт харьцангуй өндөр буюу 61.2 хувьтай байна. Энэхүү үзүүлэлтийг салбараар нь авч үзвэл үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарт үйл ажиллагаа эрхлэгч нэгжүүдийн хувьд хамгийн өндөр хувьтай буюу 84.0 хувь байна. Энэ нь 16.0 хувийн зардал гаргаж, 84.0 хувийн нэмэгдэл өртөг бий болгож байна гэсэн үг юм. Харин байр сууц болон

хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа болон үйлчилгээний бусад салбарт дунджаас доогуур буюу 45.4 болон 42.6 хувь байна.

ХҮСНЭГТ 2.12. ЖИЛИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, ЗАВСРЫН ХЭРЭГЛЭЭ, НЭМЭГДЭЛ
ӨРТӨГ, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Нийт үйлдвэрлэл-т (сая төг)	Завсрын хэрэглээ (сая төг)	Нэмэгдэл өртөг (сая төг)	Нэг нэгжид ногдох нэмэгдэл өртөг (мян. төг)	Нийт нэмэгдэл өртгийн дүнд салбаруудын эзлэх хувь
Бүгд дүн	1 663 925.0	645 359.1	1 018 565.9	6 224.6	100.0
Боловсруулах үйлдвэр	188 651.3	95 699.2	92 952.1	3 214.7	9.1
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэгээ	1 064.2	494.3	569.9	721.6	0.1
Барилга	104 405.5	22 818.1	81 587.4	6 240.7	8.0
Бөөний, жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	787 522.5	228 556.8	558 965.6	7 757.4	54.9
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	426 023.1	216 003.3	210 019.8	6 504.6	20.6
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	64 601.4	35 274.8	29 326.6	7 998.1	2.9
Бусад үйлчилгээ	91 656.9	46 512.5	45 144.4	3 513.5	4.4

Нэмэгдэл өртгийн бүтцийг бүсээр авч үзвэл баруун бүсэд 126.1 тэрбум төг буюу 12.4 хувь, хангайн бүсэд 144.2 тэрбум төг буюу 14.2 хувь, төвийн бүсэд 130.0 тэрбум төг буюу 12.8 хувь, зүүн бүсэд 29.7 тэрбум төг буюу 2.9 хувь, Улаанбаатар хотод 588.6 тэрбум төг буюу 57.8 хувь нь ногдож байна.

Судалгаанд хамрагдсан нэгжийн дүнгээр хувиараа хөдөлмөр эрхлэгч нэг нэгжийн жилийн дундаж нэмэгдэл өртгийн хэмжээ 6.2 сая төг байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгч нэг нэгжид ногдох нэмэгдэл өртгийн хэмжээг аймгуудаар авч үзэхэд Улаанбаатар хот, Баян-Өлгий аймагт хамгийн өндөр буюу 7.4-8.4 сая төг байсан бол Говьсүмбэр хамгийн бага буюу 0.6 сая төг, Сүхбаатар аймагт 2.4 сая төг байна. Баян-Өлгий аймагт худалдааны салбарт нилээд ашигтай ажилладаг байна.

ХҮСНЭГТ 2.13. ЖИЛИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, ЗАВСРЫН ХЭРЭГЛЭЭ, НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, бүсээр

Бүс	Нийт үйлдвэрлэлт (сая төг)	Завсрын хэрэглээ (сая төг)	Нэмэгдэл өртөг (сая төг)	Нэг нэгжид ногдох нэмэгдэл өртөг (мян.төг)	Нийт нэмэгдэл өртгийн дүнд бүсийн эзлэх хувь
Бүгд дүн	1 663 925.0	645 359.1	1 018 565.9	6 224.6	100.0
Баруун бүс	205 752.5	79 606.9	126 145.6	5 324.5	12.4
Хангайн бүс	244 413.1	100 260.0	144 153.1	4 747.7	14.2
Төвийн бүс	220 742.3	90 728.6	130 013.7	5 720.9	12.8
Зүүн бүс	50 450.0	20 756.7	29 693.3	3 861.8	2.9
Улаанбаатар	942 567.0	354 006.9	588 560.1	7 434.4	57.8

Нэмэгдэл өртгийг суурьшлаар нь авч үзвэл нийслэлд 587.2 тэрбум төг буюу 56.6 хувь, аймгийн төвд 289.1 тэрбум төг буюу 27.9 хувь, сумын төвд 132.8 тэрбум төг буюу 12.8 хувь, хөдөөд 9.4 тэрбум төг буюу 2.7 хувь нь ногдож байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч нэгжийн нийт үйлдвэрлэлтийн 84.6 хувь нь хотод, 15.4 хувь нь хөдөөд ногдож байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч нэгжүүдийн жилийн завсрын хэрэглээ 645.4 тэрбум төг байна. Нийт завсрын хэрэглээний 83.2 хувь нь хотод, 16.8 хувь нь хөдөөд ногдож байна.

ХҮСНЭГТ 2.14. ЖИЛИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, ЗАВСРЫН ХЭРЭГЛЭЭ, НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, суурьшлаар

	Нийт борлуулалт (сая төг)	Нийт үйлдвэрлэлт (сая төг)	Завсрын хэрэглээ (сая төг)	Нэмэгдэл өртөг (сая төг)
Бүгд дүн	2 799 189.2	1 663 925.0	645 359.1	1 018 565.9
Хот	2 408 045.0	1 407 967.7	537 018.3	870 949.3
Хөдөө	391 144.2	255 957.3	108 340.8	147 616.5
нийслэл	1 612 096.1	941 134.1	353 954.6	587 179.6
аймгийн төв	811 809.5	474 609.0	185 483.5	289 125.5
сумын төв	353 226.4	232 396.1	99 553.5	132 842.6
хөдөө	22 057.2	15 785.8	6 367.5	9 418.3

Нэг ажилтанд ногдох жилийн дундаж үйлдвэрлэлт нь 7.9 сая төг, харин нэмэгдэл өртөг нь 4.9 сая төг байна. Нэг цагийн дундаж үйлдвэрлэлт 4443 төгрөг, нэг цагийн дундаж нэмэгдэл өртөг 2744 төгрөг байна.

ХҮСНЭГТ 2.15. 1 АЖИЛТНЫ ЖИЛИЙН БОЛОН 1 ЦАГИЙН ДУНДАЖ ҮЙЛДВЭРЛЭЛ

Үзүүлэлтүүд	Нийт үйлдвэрлэлт (сая төг)	Нэг ажилтанд ногдох жилийн дундаж үйлдвэрлэлт (мян. төг)	1 цагийн үйлдвэрлэлт (төг)
Бүгд дүн	1 663 925.0	7 926.6	4 443
Суурьшилаар:			
Нийслэл	941 134.1	9 168.3	4 859
Аймгийн төв	474 609.0	7 111.6	4 256
Сумын төв	232 396.1	6 215.4	3 722
Хөдөө	15 785.8	5 031.3	3 010
Эзний хүйсээр:			
Эрэгтэй	1 066 729.8	8 456.5	4 832
Эмэгтэй	597 195.2	7 128.7	3 889
Үйл ажиллагаа явуулж буй ажлын байраар:			
Тогтсон ажлын байргүй	711 196.3	7 618.7	4 623
Тогтсон ажлын байртай	952 728.7	8 173.2	5 164
Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар:			
Боловсруулах үйлдвэр	188 651.3	4 791.3	3 748
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэгээ	1 064.2	1 347.5	798
Барилга	104 405.5	5 677.6	4 188
Бөөний, жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	787 522.5	8 575.4	4 431
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	426 023.1	12 411.3	5 862
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	64 601.4	6 975.5	3 790
Бусад үйлчилгээ	91 656.9	5 749.0	3 907

Нэг ажилтанд ногдох жилийн дундаж нэмэгдэл өртөг нь нийслэлд 5.7 сая төгрөг, аймгийн төвд 4.3 сая төгрөг, сумын төвд 3.6 сая төгрөг байхад хөдөөд 3.0 сая төгрөг байна.

Тогтсон ажлын байртай нэгжид ажиллагчдын 1 цагт бүтээж буй нэмэгдэл өртөг 3333 төгрөг байгаа нь ажлын байргүй нэгжид ажиллагчдынхаас 24.1 хувиар өндөр байна.


ХҮСНЭГТ 2.16. БҮТЭЭМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлтүүд	Нэмэгдэл өртөг (сая төг)	Нэг ажилтны жилд бүтээж буй нэмэгдэл өртөг (мян.төг)	1 цагт бүтээгдэж буй нэмэгдэл өртөг
Бүгд дүн	1 018 565.9	4 852.2	2 744
Суурьшилаар:			
Нийслэл	587 179.6	5 720.2	3 062
Аймгийн төв	289 125.5	4 332.3	2 620
Сумын төв	132 842.6	3 552.9	2 140
Хөдөө	9 418.3	3 001.8	1 872
Эзний хүйсээр:			
Эрэгтэй	627 960.6	4 978.1	2 894
Эмэгтэй	390 605.3	4 662.7	2 532
Үйл ажиллагаа явуулж буй ажлын байраар:			
Тогтсон ажлын байргүй	402 410.3	4 310.8	2 686
Тогтсон ажлын байртай	616 155.6	5 285.8	3 333
Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар:			
Боловсруулах үйлдвэр	92 952.1	2 360.8	1 867
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэгээ	569.9	721.6	440
Барилга	81 587.4	4 436.8	3 220
Бөөний, жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	558 965.6	6 086.6	3 162
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	210 019.8	6 118.5	2 892
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	29 326.6	3 166.6	1 702
Бусад үйлчилгээ	45 144.4	2 831.6	1 946

Нэг цагт бүтээгдэж буй нэмэгдэл өртгийг салбараар авч үзвэл барилгын салбарт хамгийн өндөр 3220 төгрөг, худалдааны салбарт 3162 төгрөг, тээврийн салбарт 2892 төгрөг байгаа нь улсын дунджаас 148-476 төгрөгөөр дээгүүр байна.

Нэг ажилтны жилд бүтээж буй нэмэгдэл өртгийн хэмжээ тээврийн салбарт хамгийн өндөр 6118.5 мянган төгрөг, худалдааны салбарт 6086.6 мянган төгрөг байна.

ЗУРАГ 2.10. БҮТЭЭМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, салбараар



2.1.2. “БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН СУДАЛГАА

Уул уурхайн салбарт явуулсан “Бичил уурхайн судалгаа”-ны үндсэн зорилго нь бичил уурхай эрхлэгчдийн эдийн засагт оруулж буй хувь нэмрийг тооцож, тодорхойлохоос гадна нэгжүүдийн хамрах хүрээг тогтоон бүртгэлжүүлэх, тэдгээрийн өмнө тулгарч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлох, албан ёсны статистик мэдээллийн эх үүсвэрийг бий болгох явдал байлаа.

Энэ тайланд “Бичил уурхайн судалгаа”-ны зөвхөн эдийн засагт оруулж буй хувь нэмрийг тодорхойлсон хэсгийг тусгасан болно.

Судалгааны асуулгын хуудас, түүний үзүүлэлтүүд

“Бичил уурхайн судалгаа-2012 он” судалгааны асуулгын Маягт БУС-1 нь 72 асуултыг агуулсан дараах бүлгүүдээс бүрдсэн. Үүнд:

- Бүлэг I. Хаягийн хэсэг
- Бүлэг II. Ерөнхий мэдээлэл
- Бүлэг III. Тоног төхөөрөмж
- Бүлэг IV. Ашигт малтмал олборлосноос учирсан хохирол
- Бүлэг V. Нийгэмд оруулсан хувь нэмэр
- Бүлэг VI. Тулгарч буй хүндрэл, бэрхшээл
- Бүлэг VII. Үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Судалгааны дүн

Судалгааны дүнгээр 2011 онд нийтдээ 13.4 мянган бичил уурхай эрхлэгч алт, нүүрс, жонш, гянтболд, цагаан тугалга, шохойн чулуу, үнэт чулуу зэрэг ашигт малтмалын олборлолтыг хийж байна. Бичил уурхай эрхлэгчдийн 25.3 хувь нь баруун бүсэд, 29.7 хувь нь хангайн бүсэд, 32.9 хувь нь төвийн бүсэд, 2.7 хувь нь зүүн бүсэд, 9.4 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна.

ХҮСНЭГТ 2.17. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН ТОО, бүсээр

БУС	Бичил уурхай эрхлэгчдийн тоо	Дүнд эзлэх хувь
Бүгд дүн	13 375	100.0
Баруун бүс	3 380	25.3
Хангайн бүс	3 967	29.7
Төвийн бүс	4 403	32.9
Зүүн бүс	365	2.7
Улаанбаатар	1 260	9.4

2011 онд бичил уурхай эрхлэгчид жилдээ 19806.1 сая төгрөгийн нэмэгдэл өртгийг бий болгож, 5583.6 сая төгрөгийг завсрын хэрэглээнд зарцуулсан байна. Нийт нэмэгдэл өртгийн 21.4 хувийг баруун бүс, 29.3 хувийг хангайн бүс, 33.9 хувийг төвийн бүс, 1.7 хувийг зүүн бүс, 13.7 хувийг Улаанбаатар хот бүрдүүлж байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны үр ашгийн түвшинг илтгэн харуулах үзүүлэлтийн нэг нь нэмэгдэл өртөг, нийт үйлдвэрлэлтийн харьцаа байдаг бөгөөд бичил уурхай эрхлэгчдийн хувьд энэ үзүүлэлт харьцангуй өндөр буюу 78.0 хувьтай байна.

Бүтээж буй нэмэгдэл өртгийн хэмжээгээрээ Хөвсгөл аймаг 2885.3 сая төг, Улаанбаатар хот 2717.2 сая төгрөг, Төв аймаг 2659.1 сая төг, Баянхонгор аймаг 2029.3 сая төг, Сэлэнгэ аймаг 1949.4 сая төгрөг байгаа нь бичил уурхайн үйл ажиллагаанаас хамгийн их ашиг олдог эхний 5 аймагт багтаж байна.

ХҮСНЭГТ 2.18. ЖИЛИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, ЗАВСРЫН ХЭРЭГЛЭЭ, НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, бүсээр

Бүс	Нийт үйлдвэрлэлт (сая төг)	Завсрын хэрэглээ (сая төг)	Нэмэгдэл өртөг (сая төг)	Нийт нэмэгдэл өртгийн дүнд бүсийн эзлэх хувь	Нийт үйлдвэрлэлт, нэмэгдэл өртгийн харьцаа
Бүгд дүн	25 389.6	5 583.6	19 806.1	100.0	78.0
Баруун бүс	4 890.7	654.9	4 235.7	21.4	86.6
Хангайн бүс	7 820.7	2 009.3	5 811.4	29.3	74.3
Төвийн бүс	8 903.5	2 194.5	6 708.9	33.9	75.4
Зүүн бүс	735.4	402.6	332.8	1.7	45.3
Улаанбаатар	3 039.4	322.2	2 717.2	13.7	89.4


Нийт нэмэгдэл өртгийн 80.3 хувийг дангаараа бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгч иргэд, 19.7 хувийг нөхөрлөл бүрдүүлж байна.

ЗУРАГ 2.11. БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН БҮРДҮҮЛЖ БҮЙ НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, ажил эрхлэлтийн байдлаар



Бичил уурхай эрхлэгчдийн бүтээмжийн үзүүлэлт болох нэг бичил уурхай эрхлэгчийн жилийн дундаж үйлдвэрлэлт 3.5 сая төг байгаа бөгөөд бүсээр нь авч үзвэр Улаанбаатар хотод хамгийн өндөр 4.9 сая төг, төвийн бүсэд 4.0 сая төг, хангайн бүсэд 3.6 сая төг, зүүн бүсэд 2.9 сая төг, баруун бүсэд 2.5 сая төг байна. Энэ үзүүлэлт Улаанбаатар хотод улсын дунджаас 1.4 пунктээр, төвийн бүсэд 0.5 пунктээр тус тус дээгүүр байна.

ЗУРАГ 2.12. НЭГ БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧИЙН ЖИЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛТ, сая төгрөгөөр



Нийт нэмэгдэл өртгийн бүрэлдэхүүн хэсгийн бүтцийг авч үзвэл цалин 1615.4 сая төг буюу 8.2 хувь, ажиллагчдад мөнгөн ба биет хэлбэрээр өгсөн тусламж 70.2 сая төг буюу 0.4 хувь, зээлийн хүүгийн зардал болон гамшгийн улмаас учирсан хохирлын нөхөн төлбөр 102.4 сая төг буюу 0.5 хувийг бүрдүүлж үлдсэн 18018.1 сая төг буюу 91.0 хувь нь үйл ажиллагааны цэвэр ашиг байна.

ХҮСНЭГТ 2.19. НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, бүрэлдэхүүн хэсгээр, бүсээр

	БҮГД (сая төг)	Үүнээс:				Улаан-баатар	Дүнд эзлэх хувь
		Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс		
Нэмэгдэл өртөг	19 806.1	4 235.7	5 811.4	6 708.9	332.8	2 717.2	100.0
Цалин	1 615.4	32.9	1 210.7	151.8	162.9	57.0	8.2
Ажиллагчдад мөнгөн ба биет хэлбэрээр өгсөн тусламж	70.2	18.1	11.5	37.3	2.8	0.5	0.4
Зээлийн хүүгийн зардал	99.2	27.8	14.3	38.7	17.9	0.5	0.5
Гамшгийн улмаас учирсан хохирлын нөхөн төлбөр	3.2	0.1	0.0	1.1	0.0	2.1	0.0
Үйл ажиллагааны ашиг/алдагдал	18 018.1	4 156.8	4 574.9	6 480.0	149.2	2 657.1	91.0
Нийт дүнд бүсийн эзлэх хувь	100.0	21.4	29.3	33.9	1.7	13.7	

2.2.ХУУЛЬ БУС ҮЙЛДВЭРЛЭЛ

Хууль бус үйлдвэрлэл нь ДЭЗ-ийн N2 талбарыг харуулах бөгөөд үйл ажиллагааны төрлөөр дараах 2 бүлэгт хувааж үздэг байна. Үүнд:

- a. Хуулиар зөвшөөрөгдөөгүй бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэх, тээвэрлэх, худалдах, хадгалах, бусдад дамжуулан шилжүүлэх
- b. Тухайн үйл ажиллагаа нь хуулиар зөвшөөгдсөн хэдий ч түүнийг хууль бусаар буюу зөвшөөрөлгүйгээр эрхлэх.

Худалдаа эрхлэгч, худалдан авагч хоёр талын хооронд тохиролцсон арилжааны шинж чанартай хууль бус үйл ажиллагааг (жишээ нь хар тамхины худалдаа, хулгайлсан зүйлийг дамлах, эсвэл биеэ үнэлэх) үйлдвэрлэлийн хил хязгаарт багтааж, харин талуудын хооронд тохиролцоо хийгдээгүй үйл ажиллагааг (дээрэм эсвэл хулгай) энд оруулахгүй. Иймээс талуудын хооронд тохиролцоогүй хууль бус үйл ажиллагааг гадаад хүчин зүйлийн онцгой хэлбэр гэж тодорхойлон, тэдгээрийн өртгийг үндэсний тооцоонд оруулдаггүй. Энэ удаагийн тооцоололд хууль бус үйлдвэрлэлд ихэнх жинг эзэлдэг мансууруулах бодисын худалдаа, биеэ үнэлэх үйл ажиллагааг хамруулж авч үзлээ.

Мансууруулах бодисын худалдаа, хэрэглээ

Мэдээллийн эх үүсвэр. Цагдаагийн байгууллагын холбогдох мэдээлэл, судалгаа, түүнчлэн гааль, эрүүл мэндийн байгууллагын зарим мэдээллийн эх үүсвэрт суурилан тооцооллыг хийлээ. Хураан авсан мансууруулах бодисын хувь хэмжээнд тооцооны ялгаатай нөхцлийг тавьж, эмзэг байдлын дүн шинжилгээгээр тооцоог тухай бүрд нь цаашид сайжруулж болно.

. Тооцоололд нийт хүн амд мансууруулах бодисын хэрэглээтэй хүмүүсийн эзлэх хувь, эмчлүүлж буй хүний тоо, гэмт хэргийн тоо, хураан авсан хэмжээ, мансууруулах бодисын зах зээлийн үнэ зэрэг мэдээллийг ашигласан. Түүнчлэн, хөрш орны үнийн мэдээллийг тооцоонд ашиглалаа. 2010 оны байдлаар нийтдээ мансууруулах бодис хэрэглэгчдийн тоо 400 гаруйд хүрсэн байна. 2008-2011 онуудад улсын хэмжээнд 4.2 кг героин, 19.1 кг каннабис, 30 грамм метафитамины төрлийн мөс, 15978 ширхэг мансууруулах сэтгэцэд нөлөөлөх эм илэрч хураагдсан байна.

Биеэ үнэлэх үйл ажиллагаа

Мэдээллийн эх үүсвэр. Биеэ үнэлэх үйлчилгээний дотоодын үйлдвэрлэлтийн мэдээллийн эх үүсвэр нь ҮСХ, холбогдох бусад байгууллагаас явуулсан судалгаа байлаа. Тухайлбал, ҮСХ “Биеэ үнэлэгч болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн судалгаа”-г 2010 онд явуулсан. Нийт биеэ үнэлэгчийн тоо, үүнээс гадаад хүнд үйлчилгээ үзүүлдэг биеэ үнэлэгчийн тоо, сарын дундаж орлого зэрэг мэдээлэл дээр үндэслэн тооцоог хийлээ. Улаанбаатар хотын найман дүүрэгт явуулсан 2010 оны судалгааны дүнгээр 4640 биеэ үнэлэгч байжээ.

ХҮСНЭГТ 2.20. ХУУЛЬ БУС ҮЙЛДВЭРЛЭЛ (сая төгрөг), 2010 он

	БҮГД	Мансууруулах бодис	Биеэ үнэлэх үйл ажиллагаа
Нийт үйлдвэрлэлт	27 178.0	5 853.9	21 324.1
Нэмэгдэл өртөг	27 178.0	5 853.9	21 324.1
Импорт	5 853.9	5 853.9	-

2.3.НУУГДМАЛ ҮЙЛДВЭРЛЭЛ

Нуугдмал үйлдвэрлэл нь ДЭЗ-ийн N6 талбарыг харуулна. Хууль ёсны дагуу үйлдвэрлэсэн боловч албан ёсны статистикт дараах шалтгаанаар бүртгэгдээгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ энэ ангид орно. Үүнд:

- Орлогын болон нэмэгдэл өртгийн, түүнчлэн бусад төрлийн татвар төлөхөөс зайлсхийх;
- Нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс зайлсхийх;
- Хууль ёсны зарим стандартуудыг мөрдөхөөс зайлсхийх (жишээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, ажлын цагийн дээд хязгаар, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн стандарт хангах зэргээс зайлсхийх)
- Засаг захиргааны тогтсон журмаас зайлсхийх (статистик судалгаа, захиргааны бүртгэлээс зайлсхийх)

ҮТС 2008 зөвлөмжид эдийн засгийн нуугдмал үйл ажиллагаанд захиргааны дүрэм, журам зөрчсөн үйл ажиллагааг хамруулах ба гэмт хэргийн шинж чанартай үйл ажиллагааг хууль бус үйл ажиллагааны хүрээнд авч үзэхээр тусгагдсан. Энэ удаагийн тооцоололд татвар болон нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс зайлсхийж, орлогоо нуун дарагдуулсан хэсгийг хамруулан авч үзлээ.

Мэдээллийн эх үүсвэр. Татварын хяналт шалгалтын мэдээллээс аж ахуйн нэгж, байгууллагын дутуу төлөгдсөн орлогод ногдуулсан татварын хэмжээ, хяналт шалгалт хийсэн байгууллагын тоо, ҮСХ-ны бизнес регистрийн санд бүртгэлтэй тухайн жилд үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжийн тоо зэрэг мэдээллийн эх үүсвэрийг ашигласан.

2010 оны байдлаар нийтдээ 35276 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулсан байна. Үүнээс татварын хяналт шалгалтыг 9465 ААН-д хийжээ. Тэдгээр аж ахуйн нэгж, байгууллагыг борлуулалтын орлогын ойролцоо интервиалаар бүлэглэж, тодорхой хэсгүүдэд хуваасан.

Тооцоололын үр дүнд 2010 оны байдлаар дутуу мэдээлэгдсэн 615.4 тэрбум төгрөгний үйлдвэрлэлтийг тооцлоо. Эдийн засгийн салбаруудаас нийт нуугдмал үйлдвэрлэлийн 48.6 хувь нь уул уурхай, олборлолтын салбарт, 29.6 хувь нь худалдааны салбарт ногдож байна.

ХҮСНЭГТ 2.21. ОРЛОГОО НУУН ДАРАГДУУЛСАН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН НУУГДМАЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, 2010 он

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Нийт үйлдвэрлэлт (сая төг)	Нийт үйлдвэрлэлтийн дүнд салбаруудын эзлэх хувь
Бүгд дүн	615 385.8	100.0
Хөдөө аж ахуй	8 060.2	1.3
Уул уурхай, олборлолт	299 119.6	48.6
Боловсруулах үйлдвэр	22 490.6	3.7
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	1 454.2	0.2
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэгээ	1 443.4	0.2
Барилга	35 991.3	5.8
Бөөний, жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	182 378.1	29.6
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	8 275.5	1.3
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	10 190.4	1.7
Бусад үйлчилгээ	45 982.5	7.5

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ДАЛД ЭДИЙН ЗАСГИЙН НИЙТ
ХЭМЖЭЭ

БҮЛЭГ 3. ДАЛД ЭДИЙН ЗАСГИЙН НИЙТ ХЭМЖЭЭ

Дээр дурьдсанчлан, ДЭЗ-ийг тооцох судалгаа, тооцооллын мэдээллийн эх үүсвэр цаг хугацааны хувьд ялгаатай байсныг харгалзан 2011 онд явуулсан ХХЭС-ны үр дүнг 2010 оны гүйцэтгэлд шилжүүлэх нэмэлт тооцооллыг хийсэн. Хууль бус үйлдвэрлэл, нуугдмал үйлдвэрлэлийн хувьд 2010 оны мэдээлэлд үндэслэн шууд аргаар тооцсон болно.

2010 оны байдлаар Монгол орны нийт ДЭЗ-ийн хэмжээ 1332.1 тэрбум төгрөг байгаа нь нийт эдийн засгийн 13.7 хувийг бүрдүүлж байна. ДЭЗ-д албан бус секторын үйлдвэрлэл 50.9 хувь, нуугдмал үйлдвэрлэл 46.2 хувь, хууль бус үйлдвэрлэл 2.1 хувь, өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэл 0.8 хувийн эзэлж байна.

ХҮСНЭГТ 3.1. ДАЛД ЭДИЙН ЗАСГИЙН ХЭМЖЭЭ (сая төгрөг), 2010 он

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	ДЭЗ-ИЙН ХЭМЖЭЭ	ДЭЗ-ийн асуудал бүхий анги			
		Албан бус секторын үйлдвэрлэл	Хууль бус үйлдвэр-лэл	Өрхийн өөрийн хэрэглээний үйлдвэрлэл	Нуугдмал үйлдвэр-лэл
Бүгд дүн	1 332 093.1	678 505.7	27 178.0	11 023.6	615 385.8
Хөдөө аж ахуй	8 060.2				8 060.2
Уул уурхай, олборлолт	305 661.8	6 542.2			299 119.6
Боловсруулах үйлдвэр	84 089.5	61 598.9			22 490.6
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	1 454.2				1 454.2
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэгээ	2 230.2	786.8			1 443.4
Барилга	82 511.7	39 292.1		7 228.3	35 991.3
Бөөний, жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	528 875.9	340 643.9	5 853.9		182 378.1
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	186 841.2	178 565.7			8 275.5
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	28 266.1	18 075.7			10 190.4
Бусад үйлчилгээ	104 102.3	33 000.4	21 324.1	3 795.3	45 982.5
ДЭЗ-д эзлэх хувь	100.0	50.9	2.1	0.8	46.2


Тухайн салбарын нийт эдийн засагт ДЭЗ-ийн эзлэх хувь барилгын салбарт хамгийн өндөр буюу 35.9 хувь, байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагааны салбарт 34.1 хувь, худалдааны салбарт 28.8 хувь, тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарт 22.1 хувь, уул уурхай, олборлолтын салбарт 13.4 хувь, боловсруулах салбарт 10.6 хувь байна.

ХҮСНЭГТ 3.2. НИЙТ ЭДИЙН ЗАСАГТ ДЭЗ-ИЙН ЭЗЛЭХ ХУВЬ (сая төгрөг), 2010 он

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	ДЭЗ-ийн ХЭМЖЭЭ	ДНБ	Нийт эдийн засаг (ДЭЗ-ийн хэмжээ+ ДНБ)	Нийт эдийн засагт ДЭЗ-ийн эзлэх хувь
Бүгд дүн	1 332 093.1	8 414 504.5	9 746 597.6	13.7
Хөдөө аж ахуй	8 060.2	1 203 348.0	1 211 408.2	0.7
Уул уурхай, олборлолт	305 661.8	1 981 970.1	2 287 631.9	13.4
Боловсруулах үйлдвэр	84 089.5	708 931.6	793 021.1	10.6
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	1 454.2	174 302.8	175 757.0	0.8
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэгээ	2 230.2	33 051.7	35 281.9	6.3
Барилга	82 511.7	147 178.0	229 689.7	35.9
Бөөний, жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	528 875.9	1 310 622.1	1 839 498.0	28.8
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	186 841.2	659 297.7	846 138.9	22.1
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	28 266.1	54 553.4	82 819.5	34.1
Бусад үйлчилгээ	104 102.3	2 141 249.1	2 245 351.4	4.6


ДЭЗ-ийн хэмжээг салбарын бүтцээр нь авч үзвэл худалдааны салбар 39.7 хувь, үйлдвэрийн салбар 30.1 хувь, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 14.0 хувь, барилгын салбар 6.2 хувь, байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагааны салбар 2.1 хувь, бусад үйлчилгээний салбар 7.9 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 3.1. ДЭЭ-ИЙН ХЭМЖЭЭ, салбараар (%)



ДЭЭ-ийн нэмэгдэл өртөг, нийт үйлдвэрлэлтийн харьцаа харьцангуй өндөр буюу 74.4 хувьтай байна. Энэ нь 25.6 хувийн зардал гаргаж, 74.4 хувийн нэмэгдэл өртөг бий болгож байна гэсэн үг юм. Энэхүү үзүүлэлтийг салбараар нь авч үзвэл уул уурхайн салбарт хамгийн өндөр буюу 99.1 хувь, барилгын салбарт 86.4 хувь, худалдааны салбарт 79.2 хувь, байна. Харин тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарт хамгийн бага буюу улсын дунджаас 24.0 пунктээр доогуур байна.

ЗУРАГ 3.2. ДЭЭ-ИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛТ, НЭМЭГДЭЛ ӨРТГИЙН ХАРЬЦАА, салбараар (%)



ДУГНЭЛТ

Үндэсний статистикийн хороо нь Улсын Их Хурлын 2011 оны 12 сарын 01-ний өдрийн 59 дүгээр тогтоолоор баталсан “Монгол улсын статистикийн салбарыг 2011-2015 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн “Дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоо, хамралт, мэдээллийн чанар, аргачлал, арга зүйг сайжруулах” гэсэн зорилтын хүрээнд олон улсын нийтлэг арга зүйг мөрдлөг болгож, далд эдийн засгийн хэмжээг анх удаагаа тооцон, үр дүнг хэрэглэгчдэдээ танилцуулж байна.

Судалгаа, тооцооллын үндсэн зорилго нь ДЭЗ-ийн хэмжээг тодорхойлох, түүнчлэн албан бус хөдөлмөр эрхлэлтийн хэмжээ, албан бус секторт ажиллагчдын бий болгож буй нэмэгдэл өртгийн хэмжээг тодорхойлох явдал байсан бөгөөд энэхүү зорилгоо амжилттай биелүүлээ.

Энэ удаагийн судалгаа, тооцооллыг хийхдээ өмнөх судалгааны сургамжит асуудлыг шийдвэрлэн, ДЭЗ-ийн үндсэн талбаруудыг бүхэлд нь хамруулж чадсанаараа дэвшилттэй болсон гэж үзэж байна.

ДЭЗ-ийн хэмжээг тодорхойлохын тулд хувиараа хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, хууль бус үйлдвэрлэлийн тооцоо, орлогоо нуун дарагдуулсан нэгжийн үнэлгээ зэргийг тус бүрт нь хийж дүнг нэгтгэсэн.

ДЭЗ-ийн тооцооны хамрах хүрээнд 163.6 мянган ХАА, уул уурхай, олборлолтоос бусад салбарын ХХЭН, 13.4 мянган бичил уурхай эрхлэгчдийн үйлдвэрлэлийг судалгаагаар, 35.3 мянган аж ахуйн нэгжийн дутуу мэдээлсэн үйлдвэрлэл, 5.0 мянган хууль бус үйлдвэрлэл явуулсан иргэний үйлдвэрлэлийг тооцооллоор тусгалаа.

Албан бус секторт 2011 оны байдлаар 223.3 мянган иргэн ажиллаж байна. Нийт ажиллагчдын 67.0 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч байна.

2010 оны байдлаар Монгол орны нийт ДЭЗ-ийн хэмжээ 1332.1 тэрбум төгрөг байгаа нь нийт эдийн засгийн 13.7 хувийг бүрдүүлж байна. ДЭЗ-д албан бус секторын үйлдвэрлэл 50.9 хувь, нуугдмал үйлдвэрлэл 46.2 хувь, хууль бус үйлдвэрлэл 2.1 хувь, өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэл 0.8 хувийн эзэлж байна.

ХАВСРАЛТ А - ХҮСНЭГТҮҮД

ХҮСНЭГТ 1. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ НЭГЖИЙН ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байршилаар, 2011 он

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	БҮГД		үүнээс:			
	Тоо	%	Хот		Хөдөө	
			Тоо	%	Тоо	%
Бүгд	163 636	100.0	129 490	79.1	34 146	20.9
Боловсруулах үйлдвэр	28 914	17.7	18 868	11.5	10 046	6.1
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэгээ	790	0.5	327	0.2	463	0.3
Барилга	13 073	8.0	11 506	7.0	1 567	1.0
Бөөний, жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	72 055	44.0	60 119	36.7	11 936	7.3
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	32 288	19.7	26 108	16.0	6 180	3.8
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	3 667	2.2	2 242	1.4	1 425	0.9
Мэдээлэл, холбоо	501	0.3	389	0.2	112	0.1
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	325	0.2	265	0.2	60	0.0
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	264	0.2	264	0.2	-	-
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1 766	1.1	1 185	0.7	581	0.4
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	177	0.1	177	0.1	-	-
Боловсрол	763	0.5	711	0.4	52	0.0
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	469	0.3	403	0.2	66	0.0
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1 602	1.0	1 354	0.8	248	0.2
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	6 711	4.1	5 301	3.2	1 410	0.9
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	271	0.2	271	0.2	-	-

ХҮСНЭГТ 2. ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ НЭГЖИЙН ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, аймаг, бүсээр, 2011 он

БҮС / АЙМАГ	Нийт ХХЭН-ийн тоо	Эдийн засгийн үйл ажиллагааны салбар						
		Боловсруулах үйлдвэр	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	Барилга	Бөөний, жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	Бусад үйлчилгээ
БҮГД	163 636	28 914	790	13 073	72 055	32 288	3 667	12 849
Баруун бүс	23 691	5 125	42	898	11 033	4 505	849	1 240
Завхан	5 541	947	-	-	2 640	1 199	401	353
Говь-Алтай	3 042	605	-	103	1 708	467	159	
Баян-Өлгий	4 753	489	-	291	2 705	1 024	105	138
Ховд	3 007	461	-	204	1 648	549	-	144
Увс	7 349	2 622	42	299	2 332	1 266	183	605
Хангайн бүс	30 363	7 058	239	2 600	12 844	5 082	669	1 871
Орхон	6 261	402	-	942	3 135	1 090	169	523
Өвөрхангай	7 692	2 166	71	581	2 767	1 273	130	704
Булган	1 403	349	-	307	306	256	62	123
Баянхонгор	4 267	538	105	166	2 206	1 030	-	221
Архангай	3 051	832	63	414	1 026	483	63	171
Хөвсгөл	7 688	2 771	-	189	3 405	950	245	127
Төвийн бүс	22 726	3 853	190	861	10 159	4 764	815	2 085
Төв	3 295	748	51	124	1 734	438	131	70
Говьсүмбэр	94	-	-	26	40	28	-	
Сэлэнгэ	5 944	1 236	58	365	2 337	1 396	125	428
Дорноговь	3 957	431	53	159	1 014	1 425	261	613
Дархан-Уул	6 507	780	-	187	3 515	1 036	248	742
Өмнөговь	1 500	361	27	-	774	146	51	142
Дундговь	1 430	297	-	-	746	296	-	91
Зүүн бүс	7 689	1 589	168	689	2 932	1 458	238	615
Дорнод	2 875	420	-	356	1 201	654	78	166
Сүхбаатар	1 810	318	103	258	429	316	160	226
Хэнтий	3 004	852	65	75	1 302	488	-	223
Улаанбаатар	79 167	11 289	150	8 027	35 089	16 478	1 096	7 038

ХҮСНЭГТ 3. АЖИЛЛАГЧДЫН ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажиллагчдын насны бүлгээр, 2011 он

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	БҮГД	Ажиллагчдын насны бүлэг			Дүнд эзлэх хувь
		15-24	25-60	61+	
БҮГД	209 916	19 185	187 297	3 434	100.0
Боловсруулах үйлдвэр	39 374	3 810	34 830	734	18.8
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэгээ	790	-	739	51	0.4
Барилга	18 389	2 012	16 287	90	8.8
Бөөний, жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	91 835	6 777	83 226	1 832	43.7
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	34 325	2 559	31 447	319	16.4
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	9 261	2 049	7 212	-	4.4
Мэдээлэл, холбоо	581	84	497	-	0.3
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	389	-	327	62	0.2
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	342	-	342	-	0.2
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1 912	172	1 740	-	0.9
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	177	36	140	-	0.1
Боловсрол	1 689	397	1 245	47	0.8
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	748	56	634	57	0.4
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1 941	249	1 554	138	0.9
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	7 894	984	6 805	105	3.8
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	271	-	271	-	0.1

ХҮСНЭГТ 4. АЖИЛЛАГЧДЫН ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил эрхлэлтийн байдлаар (%), 2011 он

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	БҮГД	Ажил эрхлэлтийн байдал			
		Эзэн/ ажил олгогч	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	Цалинтай ажиллагч	Гэр бүлийн бизнест цалингүй оролцогч
БҮГД	100.0	9.9	68.0	16.8	5.3
Боловсруулах үйлдвэр	100.0	10.6	62.8	18.2	8.4
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэгээ	100.0	-	100.0	-	-
Барилга	100.0	9.9	61.2	24.6	4.3
Бөөний, жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	100.0	10.2	68.3	17.4	4.2
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	100.0	5.4	88.7	4.8	1.1
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	100.0	22.0	17.6	45.2	15.2
Мэдээлэл, холбоо	100.0	6.9	79.3	13.8	-
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	100.0	16.3	67.3	-	16.3
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	100.0	22.8	54.3	-	22.8
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	100.0	5.3	87.0	7.6	-
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	100.0	-	100.0	-	-
Боловсрол	100.0	19.7	25.5	23.8	31.1
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	100.0	22.4	40.2	37.3	-
Урлаг, үзвэр, тоглоом наадам	100.0	7.3	75.3	8.8	8.6
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	100.0	8.6	76.4	8.8	6.2
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	100.0	-	100.0	-	-

ХҮСНЭГТ 5. АЖИЛЛАГЧДЫН ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, хүйсээр, 2011 он

Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	БҮГД	Ажил эрхлэлтийн байдал:		Нийт ажиллагчдад эрэгтэй ажиллагчдын эзлэх хувь
		Эрэгтэй	Эмэгтэй	
БҮГД	209 916	120 880	89 036	57.6
Боловсруулах үйлдвэр	39 374	21 860	17 514	55.5
Усан хангамж, бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэгээ	790	623	167	78.9
Барилга	18 389	14 501	3 888	78.9
Бөөний, жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	91 835	42 871	48 964	46.7
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	34 325	32 419	1 907	94.4
